



ГОВЬ-АЛТАЙ аймгийн ШАРГА сум
ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ
(2014-2024 он)



2014 он



Шарга сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөг сумын Засаг дарга М.Тунгалагтамир даргатай сумын Төлөвлөлт, хяналтын хороо, сумын ИТХТ-ийн нарийн бичгийн дарга Н.Нарантуяа ахлагчтай Ажлын хэсэг хамтран 2013 оны 11 дүгээр сараас 2014 оны 04 сар хүртэлх хугацаанд сумын төв-Баянгол багт боловсруулав.

Хөгжлийн стратеги төлөвлөгөөг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 04 дугаар сарын 18 –ний өдрийн ээлжит ҮII хуралдаанаар хэлэлцэж батлав. **Тогтоолын дугаар 07/01.**



ГОВЬ-АЛТАЙ аймгийн ШАРГА сумын хөгжлийн стратеги төлөвлөгөө нь тус сумын төр, нутгийн удирдлагын болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийт, аж ахуйн нэгжийн хамтын бүтээл бөгөөд өмчлөх, зохиогчийн эрх тус суманд хадгалагдана.

Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Төлөвлөлт, хяналтын хороо жил бүр хэлэлцэж, төлөвлөгөөний явцыг үнэлэх, шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулах, тодотгох байдлаар сайжруулж байна.

Шарга сумын хөгжлийн энэхүү төлөвлөгөөг Мерси Кор олон улсын байгууллага болон Монголын нутгийн удирдлагын холбооноос хэрэгжүүлж буй “Иргэдийн оролцоо ба орон нутгийн хөгжлийн төлөвлөлт” төслийн хүрээнд тухайн байгууллагуудын арга зүй, зохион байгуулалт, санхүүгийн дэмжлэгтэйгээр боловсруулав.



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20 14 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 0761

Баянгол

Г Сумын хөгжлийн мастер төлөвлөгөө Г
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1-ийн 2-ийн "а" дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Сумын нийгэм эдийн засгийн 2014-2024 оны урт хугацааны хөгжлийн мастер төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг жил бүрийн аймаг, сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд оруулан, хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг тухайн оны орон нутгийн төсөвт тусгуулж, үр дүнг ИТХ-д тайлагнаж, ажиллахыг сумын Засаг дарга /М.Тунгалагтамир/-д даалгасугай.
3. Сумын хөгжлийн мастер төлөвлөгөөний боловсруулалтыг нарийвчлан хянаж, 2014 оны 04 дүгээр сард багтаан хэвлэлтэнд хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч /Н.Нарантуяа/-д үүрэг болгосугай.
4. Сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнд тогтмол хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын Тэргүүлэгчдэд даалгасугай.

ДАРГА  Г.АРИУНБАЯР





ШАРГА СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА Г.АРИУНБАЯР:

МНУХ, олон улсын Мерси кор байгууллагын дэмжлэгтэйгээр “Иргэний оролцоо-Хөгжлийн төлөвлөлт” төсөлд улсын хэмжээнд хамрагдсан 120 сумд багтаж, орон нутгийнхаа хэтийн хөгжлийг өөдрөгөөр төсөөлөн төлөвлөж байгаадаа баяртай байна.

Сумын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг, төлөвлөлт хяналтын хороо болон 4 дэд хороо байгуулагдан иргэдийн санал авах ажлыг олон хэлбэрээр зохион байгуулж, нэлээдгүй олон хоног, олуулаа ажилласаны үр дүнд олны санаа оломгүй далай гэдгээр олон ургальч санааг тусгасан төлөвлөлт болсон гэж үзэж байна.

Төлөвлөнө гэдэг сайн судалж, тал бүрээс нь нягталж, хүн бүрийн үүрэг зорилгыг ойлгуулж, юуг яаж хийх, хэзээ хэн хийх, ямар хөрөнгө хүч гаргах, хаанаас дэмжлэг авах, хэн хариуцах, ямар үр дүн гарах зэргийг оновчтой тооцож боловсруулахыг хэлнэ гэж ойлгодог.

Сумын хөгжлийн мастер төлөвлөгөө батлагдсанаар манай сум хөгжлийн тольтой болж байна.

Өнөө үед сум орон нутгийн хөгжлийн сан бий болж ард иргэдийн санал санаачлага, хөгжлийн сайн төлөвлөлтөд тулгуурлан бүтээн байгуулалтыг бий болгох боломж бүрдэж байгаа нь дэвшил, бас хөгжил юм.



СУМЫН ЗАСАГ ДАРГА М.ТУНГАЛАГТАМИР

Бид 2014-2024 онд сум хөгжүүлэх мастер төлөвлөгөөгөө баг, байгууллага, иргэдээрээ хэлэлцэн уугуул, суугуул эрдэмтэн мэргэд, бизнес эрхлэгчдийн санал бодлыг сонсч боловсрууллаа. Сайн төлөвлөлт гэдэг бол хөгжлийн түлхүүр байх ёстой. Сонгуулийн үр дүнд томилогдсон удирдлагууд сумын мастер төлөвлөгөөг гол үндэс

болгон үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрөө боловсруулж ажиллахад дөхөм болсон бодлогын томоохон баримт бичиг болсон гэж үнэлж байна. Энэхүү мастер төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллахад иргэн бүрийн үүрэг оролцоо, санал санаачлага хамтын ажиллагаа чухал гэдгийг онцлон тэмдэглэмээр байна. Мастер төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлснээр сум орны хөгжил дэвшил, ард иргэдийн амьдрал ахуйд бодитой өөрчлөлт гарна гэдэгт итгэж байна.

ГАРЧИГ

ДД	Бүлэг, сэдвийн нэр, агуулга	Хуудасны дугаар
1	УДИРТГАЛ	
2	СУМЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХУРААНГУЙ	
3	Төлөвлөгөө боловсруулсан үндэслэл	
4	Төлөвлөгөөний зорилго, зорилтууд	
5	Хөгжлийн стратеги төлөвлөгөө боловсруулсан арга зүй	
6	Хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын зохион байгуулалт, зарчим, үйл явц	
7	Төлөвлөгөө боловсруулсан бүрэлдэхүүн	
8	СУМЫН ХӨГЖЛИЙН ОДООГИЙН БАЙДАЛ	
9	Сумын товч танилцуулга	
10	Нутгийн удирдлагын зохион байгуулалт	
11	Эдийн засгийн ерөнхий үзүүлэлтүүд	
12	Эдийн засгийн салбаруудын хөгжил	
13	Нийгмийн салбарын хөгжлийн байдал	
14	Байгаль орчны салбарын хөгжил	
15	Сумын эдийн засгийн чадавхийн үнэлгээ	
16	Сумын бизнесийн орчны судалгааны үр дүн ба дүгнэлтүүдийн тойм	
17	СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	
18	СУМЫН ХӨГЖЛИЙН АЛСЫН ХАРАА, ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД	
19	Сумын хөгжлийн зорилго, зорилтуудын хүрээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн тойм	
20	Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хамаарах талууд, тэдний оролцоо, хүлээх үүрэг	
21	Хөгжлийн төсөл хөтөлбөрт оролцох хөрш зэргэлдээ сумдтай хамтран ажиллах	
22	ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ	
23	ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ	
24	ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАВСРАЛТУУД	

УДИРТГАЛ

УЛСЫН ИХ ХУРАЛ 2001 ОНД “МОНГОЛ УЛСЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ”, 2008 ОНД “МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОТ СУУРИЛСАН ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГО”-ЫГ БАТАЛСНААР 2021 ОН ХҮРТЭЛ БҮС НУТГИЙН ХҮРЭЭНД АЙМАГ, ОРОН НУТГИЙГ ЭДИЙН ЗАСГИЙН ТАЛААР БИЕ ДААЛГАН ХӨГЖҮҮЛЭХ ТӨРИЙН БОДЛОГЫГ ТОДОРХОЙЛСОН. ЭНЭХҮҮ БОДЛОГОД НИЙЦҮҮЛЭН СУМЫН ТҮВШИНД ОРОН НУТГАА ХӨГЖҮҮЛЭХ ДУНД БОЛОН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ БОЛОХ АСУУДАЛ ЧУХАЛ БОЛЖ БАЙНА.

УГ АСУУДЛУУДЫГ ШИЙДВЭРЛЭХЭД НУТГИЙН ИРГЭДИЙН ИДЭВХТЭЙ ОРОЛЦООТОЙГООР ХЭРЭГЦЭЭНД СУУРИЛАН ХӨГЖЛИЙГ ТӨЛӨВЛӨХ, БИЗНЕСИЙН ТААТАЙ ОРЧИН БҮРҮҮЛЭХ, ОРОН НУТГИЙНХАА НӨӨЦ БОЛОМЖИД ТУЛГУУРЛАН ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРУУДЫГ ХӨГЖҮҮЛЭХ, ӨРСӨЛДӨХ ЧАДВАР, БҮТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨР НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАН НӨӨЦИЙГ НЬ ЗОХИСТОЙ АШИГЛАХ ЗЭРЭГ ШИНЭ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ ШИНЭЛЭГ АРГА ЗАМААР ХАНДАХ НЬ НЭН ШААРДЛАГАТАЙ БОЛЖ БАЙНА.

Төлөвлөгөөний зорилго, зорилтууд

ЗОРИЛГО-1. ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЖ, АРД ИРГЭДИЙН АЯ ТУХТАЙ АМЬДРАХ, АЖИЛЛАХ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ ХҮРЭЭНИЙ “ЗОРИЛТУУД”

1. Зам тээврийн хөгжлийг түргэтгэж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.
2. Орчин үеийн хот байгуулалтыг бий болгож, тохилог тав тухтай ажлын байр, амьдрах орчныг бүрдүүлнэ.
3. Сумын төвийн өнгө үзэмж, орчны тохижилтыг сайжруулна.
4. Мэдээлэл харилцаа холбоо, шугам сүлжээг өргөтгөн шинэчлэнэ.

ЗОРИЛГО-2. ИРГЭДЭД ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЧАНАР ХҮРТЭЭМЖТЭЙ ХҮРГЭЖ ХҮН АМЫН ӨСӨЛТИЙГ БОДЛОГООР ДЭМЖИН АЖИЛЛАЖ АМЬДРАХ ТААТАЙ ОРЧИНГ БҮРДҮҮЛНЭ. ХҮРЭЭНИЙ “ЗОРИЛТУУД”

1. Төрийн үйлчилгээг иргэдэд ил тод шуурхай хүргэж, мэргэшсэн боловсон хүчнээр хангана.
2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний орчин нөхцөл, чанар хүртээмжийг сайжруулж хүн амын өвчлөлийг бууруулна.
3. Боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, сургалтын орчинг сайжруулна.
4. Соёлын үйлчилгээний цар хүрээг өргөжүүлж, иргэдийн гоо зүйн боловсролыг дээшлүүлнэ.

ЗОРИЛГО-3. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ УУЛ УУРХАЙГ ТҮШИГЛЭСЭН БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСГИЙГ ЦОГЦООР НЬ ХӨГЖҮҮЛЭХЭД ОРШИНО. ХҮРЭЭНИЙ “ЗОРИЛТУУД”

1. Байгалийн өвөрмөц тогтоц бүхий газруудыг түшиглэн аялал жуулчлалын бааз байгуулна.
2. Байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөл, бүлгийг дэмжиж байгалийг унаган төрхөөр нь байлган, ард иргэдийг ногоон орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.
3. Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалж, хүүхэд залуучуудад сурталчлан таниулна.

ЗОРИЛГО-4. УЛАМЖЛАЛТ МАЛ АЖ АХУЙГАА ЭРХЛЭН УЛМААР ХАА-Н САЛБАРЫГ ЭРЧИМЖҮҮЛЖ, ЖДҮ-ИЙГ ХӨГЖҮҮЛНЭ. ХҮРЭЭНИЙ “ЗОРИЛТУУД”

1. Уламжлалт мал аж ахуйг эрчимжүүлж, малын үүлдэр угсааг сайжруулан сүргийн зохистой харьцааг бүрдүүлнэ
2. Газар тариалан эрхлэлтийг нэмэгдүүлж, хадлангийн талбайн ашиглалтыг сайжруулан, дэвшилтэт техник, тоног төхөөрөмжийг нэвтрүүлж, 1 га-гаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлнэ
3. Өрхийн үйлдвэрлэл болон жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэн ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулж туслах аж ахуйг эрхлэн хөгжүүлж эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангана

**СУМЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН:
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:**

Сумын Засаг даргын захирамжаар ЭЗ-ийн хөгжлийн стратеги төлөвлөгөө боловсруулах “АЖЛЫН ХЭСЭГ” байгуулагдан ажиллаж байна.



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:

Ахлагч: -Н.Нарантуяа- Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
Гишүүд: Ц.Бямбаа- Сумын Засаг даргын орлогч

Х.Төмөрбаатар-ИТХ-ын Тэргүүлэгч
Б.Бөхчулуун- ИТХ-ын Төлөөлөгч, Улаантүг багийн ИНХ-ын дарга
Б.Чулуунжав- Сондуулт багийн Засаг дарга
Д.Алтайбаатар-Сургуулийн ня-бо
Д.Ончимэг- ЗДТГ-ын ДАШБ хариуцсан

мэргэжилтэн
Төлөвлөгөө боловсруулах ажлын чиглүүлэгчээр сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Н.Нарантуяа ажиллаж байна.

ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТЫН ХОРООНЫ АЖИЛЛАХ ЗАРЧИМ

- Төлөвлөлтийн бүх шатанд олон нийтийн оролцооны аргыг ашиглах
- Нийгэм, эдийн засгийн хөгжилд голлон суурилах
- Эдийн засгийн өсөлт, ололтыг нийгэм, байгаль орчны нөхцөл байдалтай холбон тэнцвэржүүлэх
- Хувийн хэвшлийн аж ахуйн, ЖДҮ-ийн хөгжлийг дэмжих
- Төлөвлөгөөний боловсруулалт, хэрэгжилт, хяналт, үнэлгээнд төр, олон нийт, иргэд, аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн оролцоо үүргийг тодорхойлох, хангах
- Орон нутгийн нөөц боломжийг ашиглах
- Улс, аймаг, бүс нутгийн хэмжээний хөгжлийн үзэл баримтлал, хөтөлбөр, төсөлтэй уялдуулах зэрэг болно.

Төлөвлөлт, хяналтын хороо

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор сумын хөгжлийн мастер төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт үнэлгээ хийх чиг үүрэг бүхий төлөвлөлт хяналтын хороог байгуулж, мөн Тэргүүлэгчдийн 2013 оны 25 дугаар тогтоолоор дараах **4 дэд хороодыг** байгуулан ажиллалаа.

1. ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН ХӨГЖЛИЙН ДЭД ХОРОО



Ахлагч: -М.Тунгалагтамир\Засаг дарга\
Гишүүд: Н.Гэрэлмаа –Төрийн сангийн төлөөлөгч
Х.Төрбат- МЭҮТасгийн дарга
Х.Даваацэрэн- МЭҮТасгийн мэргэжилтэн
Б.Гантулга- МЭҮТасгийн мэргэжилтэн
Н.Ганзориг-ЗДТГ-ын ня-бо
Д.Алтайбаатар- Сургуулийн ня-бо
Х.Уранцэцэг- ЗДТГ-ын архив бичиг хэргийн
ажилтан
Н.Цогзолмаа -ХААН банкны эрхлэгч
П.Бямбадулам-Төрийн банкны эрхлэгч
А.Алтангэрэл- Улаан туг багийн Засаг дарга

М.Гэрэлмаа- ИТХ-ын Төлөөлөгч
Х.Төмөрбаатар-Тахийн Шарга ХХК-ний
захирал
Б.Бүрдэлбат-Дүүрэн Шарга ХХК-ний
захирал
Ж.Эрдэнэлүрэв- Дэлгэрэх Шарга хоршооны
дарга
Б.Шинэхүү- Тунамал Шарга хоршооны ня-
бо
Х.Баянмөнх- Баян-Алтай дэлгүүрийн эзэн
Э.Лхагвацэрэн- Гурван сайхан дэлгүүрийн
эзэн



2. ХҮНИЙ ХӨГЖИЛ, ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ДЭД ХОРОО

Ахлагч:Р.Оюунчимэг-ЗДТГ-ын дарга
Гишүүдэд: Ө.Гансүх-Сургуулийн захирал
М.Дариймаа-ЭМТ-ийн эрхлэгч
Д.Энхбаяр-Соёлын төвийн эрхлэгч
Б.Санчирмаа-Цэцэрлэгийн эрхлэгч
Б.Хорлоожав-НД-ын улсын байцаагч
Г.Өлзийсайхан- НХ-ийн мэргэжилтэн





Б.Дэлгэрбаяр- Улсын бүртгэгч
 Б.Чулуунжав- Сондуулт багийн Засаг дарга
 Б.Мөнхзаяа- НЭМ-ийн ажилтан
 Б.Баялагмаа- Цэцэрлэгийн ажилтан
 О.Цэрэндолом-НЭМ-ийн Лаборант

3. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ДЭД ХОРОО



Ахлагч: Ц.Бямбаа-Засаг даргын орлогч
 Гишүүд: Н.Нарантуяа- ИТХТ-ийн нарийн бичгийн дарга
 Д.Ончимэг- ЗДТГ-ын ДХШБХ –сан мэргэжилтэн
 Б.Гэрэлт-Од-Газрын даамал
 Х.Төртулга- ИТХ-ын Төлөөлөгч
 О.Зинээзэг- ИТХ-ын Төлөөлөгч
 А.Болдбаатар- ИТХ-ын Төлөөлөгч
 Б.Мандах- Баянгол багийн Засаг дарга
 Н.Гантөмөр- Татварын байцаагч
 М.Пүрэвдорж-Алтай-Улиастай” систем ТӨХ компаний сумын салбарын эрхлэгч



4. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ХӨГЖҮҮЛЭХ ДЭД ХОРОО

Ахлагч-Г.Ариунбаяр-ИТХ-ын дарга
 Гишүүд: Н.Содной- ИТХ-ын Төлөөлөгч, Тэргүүлэгч
 Л.Хишигбаяр- 12 жилийн сургуулийн багш
 Н.Идэрмөнх- ИТХ-ын Төлөөлөгч, Цаг хугацаа малчдын холбооны тэргүүн
 Б.Оюунтүлхүүр - -Байгаль орчны хяналтын

улсын байцаагч
Н.Хандмаа- ОНСМузейн ажилтан
Г.Болормаа- Цаг уурын ажиглагч



Б.Баярмаа- Баянгол багийн ИНХ-ын дарга
Х. Нарантуяа- ИТХ-ын Тэргүүлэгч, Баянгол багийн хүний бага эмч

Нэг. СУМЫН ХӨГЖЛИЙН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХУРААНГУЙ

Олон нийтийн оролцоог хангасан байдлыг хүснэгтээр үзүүлбэл

№	Оролцооны үнэлгээ	Хэдэн удаа	Хамрагдсан хүн
1	Фокус бүлгийн ярилцлага, судалгаа	5	72
2	БОС	1	80
3	SWOT шинжилгээ		
4	Олон нийтийн хэлэлцүүлэг	4	212
5	Санал асуулгын хуудас	1	126
6	Сумын чадавхийн үнэлгээ	1	280
7	Ганцаарчилсан ярилцлага	2	36
8	Мэдээллийн самбар	3	160
9	Зохион бичлэгийн уралдаан	1	13
10	ИТХ-ын төлөөлөгч сонгогчидтой уулзах	3	45
11	Багийн засаг дарга айл өрхөөр явж санал авах	2	254
12	Саналын хайрцаг	-	-
13	Санал авах дэвтэр аялуулах	-	-
14	Бусад		
Д Ү Н		23	1278

Хоёр. СУМЫН ХӨГЖЛИЙН ОДООГИЙН БАЙДАЛ

Шаргачуудын өвгөд дээдэс бол баруун Монголын ард түмний үндэсний баатар Өөлдийн Галдан бошгот, Хойдын Амарсанаа нарын үр сад Өөлд, Хойд удам угсааны хүмүүс юм.

17-р зууны сүүлчээр Галдан бошгот, Амарсанаа баатрын баруун монголын дайны хөлд тасарч суурьшсан өөлд, хойдуудын тасархай нэгэн хошууг бий болгосон.

Энэ хошууг дараа нь Засагт хан аймгийн Сүжигт гүний хошуу гэж нэрлэх болсон байна.

1755 оноос хойш 160 гаруй жил өнгөрсний дараа 1918 онд Хантайшир уулын аймгийн Сүжигт гүний хошуу болгосон.

1924 онд олон хошуудыг нийлүүлж Гурван сайхан жаргалант уулын хошуу/одоогийн Хөхморьт, Баян-Уул, Жаргалан, Шарга сум/ гэж нэрлэх болсон байна.

1931 онд Хантайшир уулын аймгийн Гурван сайхан жаргалант уулын хошуунаас 5 баг, 447 өрх, 1400 хүн ам, 41.1 мянган толгой малтай Хасагтжаргалан сумыг байгуулсан бөгөөд 1960-аад он хүртэл тус сум энэ нэрээр явж байгаад 1959 оны 12-р сард Шарга сумыг Хасагтжаргалан сумаас таслан сумын төвийг Баян голын аманд, Хасагтжаргалан сумыг Дунд шарын аманд суурьшуулсан болой.

1960 оны 3-р сард Хасагтжаргалан, Овоот сумдыг татан буулгаж Шарга сумд шилжүүлсэн юм.

Нутаг дэвсгэр, газар сангийн ангилал

Шарга сумын Газарзүйн байрлал: Шарга сум нь Говь-Алтай аймгийн төвөөс баруун тийш 89 км зайтай, далайн түвшнээс дээш 950-1200 м өндөр бөгөөд Их нууруудын хотгорын хамгийн урд захын хонхор тал газар юм. Хасагт хайрхан уулын бэлээс Төгрөг сумын Өгөөмрийн тал хүртэл 180 км, Шаргын говийн урт нь Хүйсийн говийн урд захаас Халиуны хоолой хүртэл 160 км зайтай.

Говь, тал хээр, уул хангай хосолсон 556601,0 га газар нутагтай аймагтаа томоохонд ордог сум юм. Шарга сум хойт талаараа Дарив, Зүүн хойд талаараа Баян-Уул, Зүүн тал буюу Зүүн урд талаараа Жаргалан, Тайшир сумд, Баруун урд, Баруун талаараа Халиун, Төгрөг сумдтай тус тус хиллэдэг. Дархан цаазат Хасагт хайрхан, Хантайшир, Хар азаргын нуруу, Даривын нуруу зэрэг Монгол Алтайн томоохон уул нуруугаар хүрээлэгдэн Шарга, Хүйсийн говь их нууруудын хотгорт оршдог. Нутгийн ихэнхийг Хүйс, Шаргын говиуд, Сондуулт, Ямбатын тал газар эзэлнэ.

Шарга сумын нэгдмэл сангийн ангилал /га/ Нийт газар нутаг-556601.0 га

Газрын ангилал	Газрын хэмжээ	Нийт талбайд эзлэх хувь
Хөдөө аж ахуйн газар	488104	87.64
Ойн сан бүхий газар	49502	8.9

Тусгай хамгаалалтын газар	14880	2.7
Усан сан бүхий газар	1765	0.3
Тосгон суурингийн газар	350	0.1
Дэд бүтцийн газар	2000	0,36

Хүн ам зүй

2013 оны жилийн эцсийн байдлаар 565 өрхөд 1947 хүн амьдарч байгаа ба нэг өрхөд дунджаар 3 хүн амьдарч байгаа нь улсын дунджаас багавтар байна. Сумын нийт хүн амын 47,8% нь эмэгтэй, 52,2% ийг эрэгтэйчүүд эзэлж байна. Өрх толгойлсон эмэгтэй 101, эрэгтэй 43.

Хүн амын насны бүтцээр нь авч үзвэл 0-16 насны хүүхдүүд 31.1 %, 16-35 насны залуучууд 32,3 %, 36-54 насны идэрчүүд 26,02% , 55-с дээш насны ахмад 10.47 %-ийг тус тус эзэлж байна.

Шилжилт хөдөлгөөн

Сүүлийн 6 жилийн дунджаар жилд 52 хүүхэд төрж, 14 хүн нас барж жилд дунджаар 3 хүнээр өссөн байгаа нь 1990-ээд онтой харьцуулбал төрөлт багасч байна. Сүүлийн жилүүдэд төрөлт ялимгүй өссөн байна.

2013 онд жилд 105 хүн шилжин явж, 69 хүн шилжин ирсэн ба жил бүр шилжин ирсэн хүнээс шилжин явсан хүний тоо 20-30 хүнээр илүү байдаг. Шилжилт хөдөлгөөн ихэсч байгаа нь дэд бүтэц хөгжөөгүй, аймгийн төвтэй ойр болон улсын нийслэлээс хэт алслагдсантай холбоотой гэж үздэг.

Цаг агаарын нөхцөл байдал

Хуурайдуу халуун зунтай, хахир өвөлтэй.

- 1 дүгээр сарын дундаж температур -27.9 °C
- 7 дугаар сарын дундаж температур +27.4 °C
- жилийн дундаж салхины хурд 4-8 м/с
- жилийн хур тунадасны нийлбэр 38 мм
 - Хамтын хүч багт цасны зузаан 16 см
 - Улаан туг багт цасны зузаан 10 см
 - Сондуулт багт цасны зузаан 10 см байдаг.

Баянгол, Хамтын хүч, Сондуулт, Улаан туг багт ургамлын ажиглалт бэлчээрийн төлөв байдлыг тодорхойлох зогсоол цэгтэй. Сумын төвд 120 м² талбай бүхий цаг уурын ажиглалтын талбайтай.

Гадаргын болон гүний усны нөөц

Сумын төвд усны эх үүсвэрийн 3 гүний өрмийн худагтай, 35м³ багтаамжтай 1 усан сантай, ус зөөлрүүлэх, цэвэршүүлэх тоног төхөөрөмж тавигдсан, ундны усны эргэн тойрон хамгаалалтын бүс тогтоосон, усаа худгаас зөөж хэрэглэдэг. Сумын хэмжээгээр гүн өрмийн 15 худаг, 80 гаруй гар худаг, 40 гаруй гол горхи, булаг шанд байдаг.

Газар тариалангийн үйлдвэрлэлийн зориулалттай ус нөөцлөх 2 усан сантай.

Ургамал- Манай сумд хээрийн бэлчээрт зонхилох ургамал таана, хөмүүл, саман ерхөг, хялгана, хамхуул, мангир, агь, зээргэнэ, арзгар согсойлж, гэсэр, зэрэг ургамал байна. Говь талдаа улалжийн төрлийн ургамал /ширгэ, гичгэнэ, / зонхилж байна. Модлог, бутлаг ургамлаас заг, сухай, бударгана, гоёо, харгана, тэсэг, шаваг, бахлуур, ууландаа шинэс, улиас, ортууз, бургас, улаан сухай, олон төрлийн эмийн ургамал вансэмбэрүү, бамбай, гадигар, алтангагнуур, арц, чихэр өвс, таван салаа, цагаан мөөг, далиг яргай нэн ховор балга, зэрэг ургамал мод бий.

Амьтан- Говь болон цөлийн бүсийн нэн ховор хийгээд ховордсон амьтдаас Монгол бөхөн зэгсний гахай, хар сүүлт, цагаан зээр, мөлхөгчдөөс хонин гүрвэл, могой, жигүүртнээс Алтай хойлог, ятуу, хахилаг, ёл, тас зэргээс гадна хээрийн бүсийн шувуудын гол бүрдэл болох монгол болжмор, талын бүргэд, тэрчлэн говь цөлийн бүсийн тоодог, хулан жороо, чогчого, зэрийг нэрлэж болно. Мөн Монголын улаан номонд орсон аргаль, янгир, ирвэс, буга, зэрэг ховор амьтад байдаг. Хөхтөн амьтдаас тарвага, үнэг, чоно, суусар, шилүүс, жирх, туулай,

Байгаль орчин, газарзүйн байдал, хил хизгаар: Шарга сум хойт талаараа Дарив, Зүүн хойд талаараа Баян-Уул, Зүүн тал буюу Зүүн урд талаараа Жаргалан, Тайшир сумд, Баруун урд, Баруун талаараа Халиун, Төгрөг сумдтай тус тус хиллэдэг. Дархан цаазат Хасагт хайрхан, Хантайшир, Хар азаргын нуруу, Даривын нуруу зэрэг Монгол Алтайн томоохон уул нуруугаар хүрээлэгдэн Шарга, Хүйсийн говь их нууруудын хотгорт оршдог. Нутгийн ихэнхийг Хүйс, Шаргын говиуд, Сондуулт, Ямбатын тал газар эзэлнэ.

Манай сум Говь хээрийн талархаг, Алтайн уулархаг мужийг харуулсан Их нуурын хотгорын бүсэд багтдаг. Жилийн дөрвөн улирлын онцлогийг алтан шаргал өнгө жавхаагаар хадгалсан нутаг юм. Хасагт хайрхан уулын өвөрт Хойт шарын буюу Нүхэн голоос эх авсан Хойт голын эх, Өргөн ширэг, Тэгш, Дунд шарын голоос эх авсан Булгын эх, Хотно, Цагаан байшин, Зах, Урд шарын голоос эх авсан Урд гол болон Баянгол, Элсэн бөөрөг зэрэг олон гол горхи, булаг, шандууд урссаар Шаргын голд нийлнэ.

Хөрс: Говь нутагт талархаг ба хотгор газрын хөрс зонхилох бөгөөд хүрэн, цайвар хүрэн, нимгэн давхаргатай цайвар хүрэн, цөлийн цайвар бор, цөлөрхөг хээрийн нугат бор, цөлийн бор саарал, хэт гандуу цөлийн гөлтгөнөтэй нимгэн давхартай борзонт марз, мараа, элс бүхий хэв шинжийн хөрс тархан бүрэлдсэн.

Ус зүй: Говь-Алтай аймгийн нутаг гадаргын усны хуваарилалтаар Монгол Алтайн ар хажуу болон өвөр хажуугийн мужид багтах бөгөөд Төв азийн гадагш урсгалгүй ай савд багтах Сутай хайрханаас эх авсан Зүйлийн гол, Хасагт Хайрханаас эх авч Шаргын говьд шургадаг Гурван шарын гол байдаг. Сумын хэмжээнд 2011 оны улсын тооллогоор булаг

шанд- 53, Гол- 29, Нуур Тойром-5, Худаг-27 гэж тоологдсон. Аймагтаа томоохон нуурт орох Цагаан нуур /хоолны давстай/-15700 М² талбайтай хужир шүү бэлддэг, Их устай.

Байгалийн үзэсгэлэнт газар: Хасагт хайрхан уул Говь-Алтай аймгийн Шарга, Жаргалан, Баян-Уул, Тайшир сумдын нутагт Их нуруудын хотгор руу гүн түрж орсон Алтайн салбар уулсын нэг билээ. Энэ уулын буга, аргаль, янгир, ирвэс зэрэг ховор ан амьтдын өлгий нутаг бөгөөд байгалийн үзэсгэлэнт байдлыг хамгаалах зорилгоор 1965 онд АИХ-ын Тэргүүлэгчдийн 17 дугаар зарлигаар дархан газар болгосон. Улсын туснай хамгаалалттай газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай УИХ-ын 1995 оны 26 дугаар тогтоолоор дархан цаазат газрын ангиллаар баталгаажуулсан. Талбайн хэмжээ 27448 га. Эгц цавчим хажуутай, хурц шовх оргилтой 2 зэрэгцээ нуруунаас бүрдэх бөгөөд хойт талыг Хасагт Хайрханы нуруу, өмнө талыг Гурван богдын нуруу гэнэ.

Байгалийн үзэсгэлэнт болон дурсгалт газрууд


Сумын бахархал



Нүхэн шарын хүрхрээ



Рашаантын эх



Гурван богд хайрхан



Балга мод



Таван цулын рашаан
Сумын хөгжлийн зарим үзүүлэлтүүд



Заган ой, бөхөн гөрөөс

а. Ерөнхий мэдээлэл

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
Байршлын үзүүлэлтүүд		
Улсын нийслэлээс	Км	1089
Хүн ам төвлөрсөн зах зээл	Км	байхгүй
Хилийн гарц	Км	байхгүй
Бүсийн төв	Км	байхгүй
Нийт нутаг дэвсгэр	Га	556601.0
ХАА-н эдэлбэр газар	Га	488401.0
Бэлчээр	Га	488778.0
Тариалангийн талбай	Га	556.0
Үүнээс: Тариалдаг талбай	Га	556.0
Усны эдэлбэр газар	Га	1765.0
Тусгай хамгаалалттай газар	Га	12924.0
Зам, шугам сүлжээний газар	Га	433.0
Хот, суурины эдэлбэр газар	Га	341.0
Уул уурхайн газар	Га	
Далайн түвшнээс дээш хэдэн метр өндөр	М	1020
Байгалийн ямар бүсэд хамардаг		
Жилийн дундаж температур	Градус	6.2
Зуны дулааны температур дунджаар	Градус	39.2
Өвлийн хүйтний температур дунджаар	Градус	36.6
Жилийн дундаж хур тундас ОЖД	Мм	2.8

Хуртай жилийн хур тундас тах	Мм	27.3
Нөхөрлөл	Тоо	5
Компани	Тоо	9
Хоршоо	Тоо	2
Улсын үйлдвэрийн газар	Тоо	
Төсөвт байгууллага	Тоо	5
Төрийн бус байгууллага	Тоо	5
Шашны байгууллага	Тоо	
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Тоо	

б. Хүн ам, зүй, нийгмийн хөгжлийн зарим үзүүлэлтүүд

	2009	2010	2011	2012	2013
Сумын нийт хүн ам	1921	1899	1839	1900	1947
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	1138	1095	1078	923	1042
Ажил эрхэлдэг хүн ам буюу ажиллагчид	1120	1080	1068	913	861
Ажиллагчид, үйлдвэрлэлийн салбараар:					
• Мал аж ахуй	840	834	824	710	
• Цахилгаан дулаан	2	3	3	3	3
• Холбоо , тээвэр	1	1	1	1	1
• Худалдаа үйлчилгээ	25	26	27	29	30
• Төрийн захиргааны байгууллага	34	34	34	35	36
• Боловсрол	56	58	60	61	62
• Эрүүл мэнд	22	24	24	25	25
• Бусад	152	110	105	60	60
Хөдөлмөрийн насны хүн ам:	1210	1195	1188	1033	1042
Ажилгүйчүүдийн тоо	15	18	10	11	24
Үүнээс: эмэгтэй	9	8	5	5	15
Ажилгүйдлийн түвшин,%	1.3	1.6	1.0	1.2	2.3
Сумын өрхийн тоо	564	562	560	558	565
Ядуу	112	120	110	103	98
Нэн ядуу	40	62	58	52	50
Малтай өрхийн тоо бүгд, үүнээс:	505	517	490	485	473
50 хүртэл малтай	58	162	112	110	107
51-100 малтай	81	110	84	70	78
101-200 малтай	173	140	136	145	111
201-500 малтай	166	96	139	140	151
501-ээс дээш малтай	27	9	19	20	26
Малчин өрхийн тоо	440	434	430	385	385
Малчдын тоо					760

в. Мал аж ахуйн салбарын хөгжлийн үзүүлэлтүүд
Сумын хөдөө аж ахуйн өнөөгийн байдал

ШАРГА СУМЫН МАЛЫН ТОО /сүүлийн 5 жилээр/


Малын төрөл	2009	2010	2011	2012	2013
Адуу	3873	2364	2742	3152	3525
Үхэр	3731	1615	1954	2528	3028
Тэмээ	3635	3357	3358	3606	3820
Хонь	19646	11571	14855	17247	20658
Ямаа	70631	43474	59488	66365	75515
Нийт малын тоо	101516	62381	82397	92898	106546



г. Газар тариалангийн салбарын хөгжлийн үзүүлэлтүүд
ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Он	Тариалсан талбайн хэмжээ /га/			Авсан ургацын хэмжээ /тонн/				
2009	75	Үүнээс	Үр тариа	30	535	Үүнээс	Үр тариа	35
			Төмс	30			Төмс	310
			Хүнсний ногоо	15			Хүнсний ногоо	190
2010	65	Үүнээс	Үр тариа	30	424.5	Үүнээс	Үр тариа	34.5
			Төмс	20			Төмс	240
			Хүнсний ногоо	15			Хүнсний ногоо	150
2011	65	Үүнээс	Үр тариа	25	388	Үүнээс	Үр тариа	28
			Төмс	23			Төмс	20
			Хүнсний ногоо	17			Хүнсний ногоо	153

2012	66	Үүнээс	Үр тариа	25	257	Үүнээс	Үр тариа	17.5
			Төмс	23			Төмс	149.5
			Хүнсний ногоо	18			Хүнсний ногоо	90
2013	50	Үүнээс	Үр тариа	150	200	Үүнээс	Үр тариа	10
			Төмс	20			Төмс	130
			Хүнсний ногоо	15			Хүнсний ногоо	60



Д.

Орон нутгийн төсөв, сая төгрөг



Орон нутгийн төсвийн орлого	34456800	37614349	55844132	72705746	19208347
Хүн амын орлогын албан татвар	24072900	30951799	38903578	50726142	-
Бууны албан татвар	230000	176000	314000	334000	294000
Ойн гоожин					
Газрын төлбөр	929000	2487160	2618000	2139600	-
Ус ашигласны төлбөр	50000	2020000	2360000	2375500	1998787
Хүү торгууль	901600	234800	274200	2057114	6966000
Бусад орлого	307100	315270	80000	517000	8157000

Орон нутгийн төсвийн зарлага	72836.4	95209.6	138682.9	162599.0	567535135
Цалин	50640.7	57577.7	74041.2	103435.1	178408230
НДШ, ЭМД	5722.0	6488.8	8250.4	11560.8	19839475
Гэрэл цахилгаан	3288.4	4000.0	1249.3	1366.1	650894
Тээвэр шатахуун	3342.7	9649.9	13819.6	12286.6	16447400
Шуудан холбоо	374.5	811.7	1038.9	998.2	1927967
Албан томилолт	2652.5	4265.0	5475.0	6792.5	10155500
Бусад зарлага	6815.4	12416.5	34808.5	26159.8	5184350

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ШАРГА СУМЫН ЕРӨНХИЙ SWOT ШИНЖИЛГЭЭ

<i>Давуу тал</i>	<i>Сул тал</i>
Аймагт ойрхон	Аймагт ойрхон
Байнгын цахилгааны эх үүсвэртэй	Хүн ам цөөн
Үүрэн холбоотой 4 сүлжээтэй	Үйлдвэр үйлчилгээ хөгжөөгүй
Баруун аймаг болон баруун бүсийн сумдын зам нутаг дэвсгэр дээгүүр дайран өнгөрдөг	Нийтийн халаалтгүй
Мал аж ахуй, газар тариалан хослон эрхлэх боломжтой	Цэвэр бохир усны сүлжээгүй
Хадлангийн 1800 га газартай	Эрс тэс уур амьсгалтай
<i>Боломж</i>	<i>Саад бэрхшээл</i>
Эрчимжсэн МАА, түүний дотор тэмээ, үхрийн аж ахуй эрхэлж МАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэх	Санхүүгийн бэрхшээл
Жимс жимсгэнэ, хүнсний ногоо, малын тэжээл тариалах	Зах зээл
Үзэсгэлэнт газруудыг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх	Хүн амын шилжилт хөдөлгөөн ихтэй
Баруун бүсийн сумдын төв болох	Улаан туг, Сондуулт багийн иргэд ихэнх нь аймагт төвлөрсөн
Газар тариалан аймгийн түшиц газар болох	

3.2. Нутгийн удирдлагын зохион байгуулалт

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал


Говь-Алтай аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1992 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр шийдвэрээр Шарга сумын **Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал** байгуулагдан, ИТХ-ын Тэргүүлэгчдийн анхны даргаар Цэвээний Бямбаа, нарийн бичгийн даргаар Ядамжавын Хажидмаа нар ажиллаж, орон нутагт Нутгийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлж эхэлсэн түүхтэй.

Тус сумын анхны Засаг даргаар Очирбатын Пунцагдаш ажиллаж байсан бөгөөд 1992-1995 онд ИТХТ-ийн дарга, 1996-2003 онд ИТХ-ын нарийн бичгийн дарга орон тооны бус байдлаар ажиллаж байгаад 2004 оноос эхлэн албан ёсны 2 орон тоотой болсон байна.

Орон нутгийн сонгуулийн үр дүнгээр бүтэц бүрэлдэхүүнээ шинэчлэн ажилладагаараа НӨУЁБ-ын онцлогтой бөгөөд 2012 оны 6 дахь удаагийн сонгуулиар 15 төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй сонгогдон ажиллаж байна.



Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын SWOT шинжилгээ

Давуу тал

Сул тал

- | | |
|---|---|
| <ul style="list-style-type: none"> • Орон нутгийнхаа асуудлыг бие даан шийдвэрлэх бүрэн эрхтэй • Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа тогтворжиж бүх талаар төлөвшсөн • Иргэдийн сонголтоор томилогдон ажилладаг | <ul style="list-style-type: none"> • Улс төрийн өнцгөөс асуудалд хандах магадлалтай • Жижиг тойргоос сонгогддог тул сонголт амжилтгүй болох магадлалтай • Анхан шатны нэгж БИНХ-ын үйл ажиллагаа тогтмолжоогүй |
|---|---|

- Ажлаа иргэдээрээ дүгнүүлдэг
- Гарсан шийдвэр нь хэрэгжих боломжтой

Боломж

- Сумын ИТХ-ын үйл ажиллагааны цар хүрээ өргөжиж, ажиллах орчин нөхцөл тодорхой түвшинд нэмэгдсэн
- Төлөөлөгчид, тэргүүлэгчдийн идэвх оролцоо, мэдлэг чадвар өссөн
- Хурлын байгууллагатай хамтран ажиллах иргэдийн идэвх оролцоо дээшилсэн
- Орон нутгийнхаа тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хөрөнгийг иргэдийн оролцоотой хуваарилдаг болсон

Саад бэрхшээл

- Холбогдох хуулиудад өөрчлөлт оруулж, эрх зүйн орчинг боловсронгуй болгон, тогтворжуулах /МУ-ын үндсэн хууль, ЗЗНДНТУ, Орон нутгийн сонгуулийн тухай хууль гэх мэт/
- Сумын ИТХ-ын төлөөлөгчид тойрогтоо ажиллах зардалгүй болохоор төлөөлөгч сонгогчдын хоорондын уялдаа холбоо бага
- Хурлын байгууллагын бүтэц орон тоо цөөн
- Иргэний танхим ажиллах боломж муу

Тулгамдаж буй асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
➤ Хурлын ажлын албаны бичиг хэргийн ажлын ачаалал их	<ul style="list-style-type: none"> • Архив бичиг хэргийн буюу Иргэний танхимын ажилтан зайлшгүй шаардлагатай • БИНХ-ын даргыг техник тоног төхөөрөмжөөр хангаж, бичиг баримтаа боловсруулах боломжийг бүрдүүлэх
➤ БИНХ-ын даргын ажиллах орчин нөхцөл бүрдээгүй	БИНХ-ын даргыг орон тооны болгож, үйл ажиллагааг тогтмолжуулах
➤ Иргэний танхимын байр жижиг, шаардлагатай техник хэрэгсэлгүй	Иргэний танхимын байрыг өргөтгөж, камер, проектор зэрэг тоног төхөөрөмжөөр хангах
➤ Сумын ИТХ-ын төлөөлөгчид, тэргүүлэгчдийн үр дүнтэй ажиллах боломж муу	Тэргүүлэгчдийг урамшуулалтай болгож, төлөөлөгчдийн тойрогтоо ажиллах зардалтай болгох

Сумын Засаг даргын Тамгын газар

Эрхэм зорилго

Төрөө дээдэлж иргэдээ хүндэлсэн чадварлаг мэргэшсэн баг хамт олон байна.

Тус байгууллага нь 1992 он хүртэл сумын Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа нэртэй үйл ажиллагаа явуулж байсан.

1992 оноос үйл ажиллагааны чиг үүрэг өөрчлөгдөн Засаг даргын Тамгын газар нэртэй болж, Монгол улсын засгийн газраас баталсан бүтэц, орон тооны хязгаарыг мөрдөн ажиллаж байна.

Засаг даргын Тамгын газрын анхны даргаар Бадамгаравын Баянмөнх ажиллаж байлаа.

Байгууллагын үндсэн чиг үүрэг

-Хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах

-Иргэдэд төрийн захиргааны үйлчилгээг үзүүлэх

-Нутаг давсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн төлөвлөлт хийх, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах

-Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд зохион байгуулалт, эрх зүйн талаар туслах

Бүтэц, бүрэлдэхүүн

Тус сумын Засаг даргын тамгын газар Засгийн газраас тогтоосон бүтэц, орон тооны хязгаарыг баримтлан үйл ажиллагаа явуулж байна.

- 1.Засаг дарга
2. Засаг даргын орлогч
- 3.Тамгын газрын дарга
- 4.Төрийн сангийн төлөөлөгч
- 5.Дотоод ажил, шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн
- 6.Мал эмнэлэг үржлийн тасгийн дарга
- 7.Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн
- 8.Газар тариалан, жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн
- 9.Байгаль орчны бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
- 10.Газрын даамал
- 11.Нягтлан бодогч
- 12.Архив-бичиг хэргийн ажилтан
- 13.Жолооч
- 14.Нярав үйлчлэгч
- 15.Галч 4 ажиллана.

- ❖ 4 багийн Засаг дарга
- ❖ Удирдлагын босоо тогтолцоотой 7 мэргэжилтэн
 1. Нийгмийн даатгалын байцаагч
 2. Татварын байцаагч
 3. Халамж үйлчилгээний ажилтан
 4. Улсын бүртгэгч
 5. Хэсгийн төлөөлөгч
 6. цагдаа
 7. Цаг уурч



2013 оны төсөв

- ❖ ЗДТГ-ын төсөв: 189 сая, 506 мянга, 700 төгрөг
- ❖ Багийн төсөв: 37 сая, 403 мянган, 400 төгрөг

Ажлын амжилт

2011 оны ажлаар аймагт 3 дугаар байр

2012 оны ажлаар аймагт 1 дүгээр байр

2013 оны ажлаар аймагт 3 дугаар байр эзэлсэн байна.

Сумын ЗДТГазрын SWOT шинжилгээ

Давуу тал

- ❖ Боловсон хүчний хангалт боломжийн
- ❖ Мэргэжилтнүүдийн нийгмийн оролцоо идэвхи, ажлын хариуцлага сахилга бат сайн
- ❖ Байгууллагын ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, хэтийн төлөвлөлт сайн
- ❖ Багаар ажиллах чадвартай
- ❖ Удирдлагын арга барилын ажлын туршлагатай

Сул тал

- ❖ Албан конторын өрөө тасалгааны тоо, хүрэлцээ хангалтгүй
- ❖ Албан контор зориулалтын бус дээвэр муудсан.
- ❖ Интернет байхгүй, мэдээллийг хугацаа алдаж авдаг.
- ❖ Мэргэжилтнүүдийн ашиглаж байгаа техник тоног төхөөрөмж хүрэлцээ муу, ажлын шаардлага хангадаггүй.

Боломж:

- ❖ Харилцаа холбоо хөгжсөн.
- ❖ Цахилгааны найдвартай эх үүсвэртэй
- ❖ Хууль эрх зүйн ажил явуулах зардал байдаггүй.

Саад бэрхшээл:

- ❖ Иргэдийн нийгмийн идэвх сул
- ❖ Зарим эрх зүйн баримт бичгийн заалтууд зөрчилтэй.
- ❖ Төрийн захиргааны албан хаагчийн цалин, урамшуулал бага
- ❖ Буцалтгүй тэтгэмж өгдөггүй

Тулгамдаж буй асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд

Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд

Албан конторын дээвэр муудсан байнга дээвэрээс дусаал гоождог

Ойрын жилд шинэ барилгын асуудал шийдвэрлэх

Урсгал засварын зардал бага

Урсгал засварын зардлыг өсгөх

Эдийн засаг, салбаруудын хөгжил

Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хөгжил:

Худалдаа үйлчилгээ:

Шарга сумд 1957 онд анхны үйлвэрлэл, үйлчилгээний суурь бий болж байсан. Нэгдэл нийгмийн үед худалдаа бэлтгэлийн анги ард иргэдийг бараа таваараар хангаж байсан. Зах зээл эдийн засгийн шилжснээр сумд худалдаа үйлчилгээний салбарыг “Тахийн Шарга”ХХК-ий Тахийн шарга 8 нэрийн барааны дэлгүүр, “Дүүрэн Шарга”ХХК-ий Дүүрэн Шарга 8 нэрийн барааны дэлгүүрүүд тэргүүлж, 2011 оноос эхлэн хувиараа бизнес эрхлэгч Х.Баянмөнх, Э.Лхагвацэрэн нарын байгуулсан “Баян Алтай”, “Гурван сайхан” хүнс барааны

дэлгүүрүүд болон “Тунамал Шарга” хоршоо ард иргэдэд худалдааны үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

Худалдаа, үйлчилгээний салбарын SWOT шинжилгээ:

Давуу тал

- Гэрэл цахилгааны эх үүсвэр найдвартай болсон учир хүмүүс үйлдвэрлэл үйлчилгээний явуулах санаачлага нэмэгдсэн.
- Худалдааны цэгүүд стандарт хангасан, орчин цэвэрхэн.
- Бараа, хүнсний бүтээгдэхүүний үнэ харьцангуй хямд байдаг./аймгийн үнээр/

Боломж

- Ажлын байрыг нэмэгдүүлэх, хүн амын шилжилт хөдөлгөөнийг зогсоох, хувиараа бизнес эрхлэгчдийг орон нутгаас дэмжих.

Сул тал

- Аймагт ойрхон хүн амын шилжилт хөдөлгөөн их.
- Хүмүүсийн гар дээр бэлэн мөнгө ховор, ажлын байр цөөн байна.
- Цаг, уурын байдал.
- Бараа, хүнсний бүтээгдэхүүний эргэлт удаан.

Саад бэрхшээл

- Валютын ханшны тогтворгүй байдал.
- Хувийн байгууллагын үйл ажиллагаанд төрийн оролцоо , дарамт их байдаг.
- Татварын тогтолцоо уялдаагүй чирэгдэлтэй байдаг
- Хүн ам цөөн, зах зээлийн багтаамж бага

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд

Төрөөс жижиг бизнес, хувиараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тал дээр муу байна.

Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд

1. Худалдаа үйлчилгээний салбарыг хөгжүүлэхийн тулд төрийн оролцоог багасгах.
2. Асуудлыг шийдвэрлэхдээ судалгаанд түшиглэн, үнэн зөв дүгнэлт хийх.

Аливаа санаачлан хийж байгаа хүмүүсийг зээлд хамруулж байх

Жижиг, дунд үйлдвэрлэл



Жижиг, дунд үйлдвэрлэлийн SWOT шинжилгээ:

Давуу тал

- Газар тариалан мал аж ахуй хослон эрхэлдэг.
- Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэхэд хөрс, цаг агаарын нөхцөл тохиромжтой

Боломж

- Зээлээр ЖДҮ эрхлэх, хөгжүүлэх
- Гэрэл цахилгааны хүрэлцээг нэмэгдүүлэх

Сул тал

- Иргэдийн газар тариалан, мал аж ахуй эрхлэх идэвх суларсан.
- Хүн ам цөөтэй,
- Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд ашиг муу

Саад бэрхшээл

- Иргэдийн хөдөлмөрлөх идэвх сул
- Бүтээгдэхүүний борлуулалт удаан
- Зээлийн хүү өндөр

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд

Хүн амын тоог нэмэгдүүлэх, иргэдэд чанартай амьдралын сэдлийг бий болгох

Мэргэжлийн чиг баримжаа муутай

Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд

Хүн амын тоог олон болгох

Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд өргөн хамруулах

Уул уурхай, олборлох үйлдвэрлэл:

Тус сумд ашиглалтын зөвшөөрөлтэй 1 ХХК, хайгуулын зөвшөөрөлтэй талбай 10 байна.

Металл Импекс ХХК нь хөнгөн цагаан олборлох, ашиглах эрхтэйгээр 2012 онд АМЕГ-аас зөвшөөрлөө авсан. Одоогоор үйл ажиллагаагаа эхлээгүй байна.

Хайгуулын 7 талбайд соронзон хайгуулын зураглал, 3 талбайд өрмийн ажил хийгдэж байна.

Никуайро ХХК-ий **Шарга-1, 2, Дарви Шаргын нуруу** гэх 4 талбайд 6 дахь жилдээ зураглалын ажил хийгдэж байна.

Форсконстракшн ХХК-ий **Олгой цагаан талбайд** 9 дэх жилдээ зэсний хайгуулаар өрмийн ажил явуулж байна.

Зэст-Алтай ХХК-ий **Хар толгой талбайд** 8 дэх жилдээ нүүрсний хайгуулаар өрмийн ажил явуулж байна.

Самтан морес ХХК-ий **Майхан улаан талбайд** 8 дах жилдээ зэсний хайгуулаар өрмийн ажил явуулж байна.

Жил бүр байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөөгөө батлуулан үйл ажиллагаа явуулдаг Форсконстракшн ХХК, Никуайро ХХК-иуд байна.

Мөн усны дүгнэлт гаргуулж, гэрээ байгуулан сумын төсөвт өнгөрсөн онд усны төлбөрт 304833.35 төгрөгийг байршуулсан байна.

Олборлох үйлдвэрийн ил тод байдлыг хангах үүднээс АМЕГазарт компаниуд тухайн жилийн ажлын тайлангаа хүргүүлж, тухайн нутгийн иргэдэд үйл ажиллагаа, тайлангаа танилцуулж байна.

Тулгамдаж буй асуудлууд

- Нөхөн сэргээлтийг буруу, дутуу хийснээс газар, хүн, амьтанд учрах бэрхшээл их
- Иргэдийн уурхайн талаарх буруу ойлголт

Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд

- Иргэдийн буруу ойлголтыг зөв хандлагад оруулах
- Нөхөн сэргээлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх
- Ашиг хүртэгч нь нутгийн иргэд байхаар гэрээ байгуулах

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Аялал жуулчлал:

Манай сум Говь хээрийн талархаг, Алтайн уулархаг мужийг харуулсан Их нуурын хотгорын бүсэд багтдаг. Хасагт хайрхан уулын өвөрт Хойт шарын буюу Нүхэн голоос эх авсан Хойт голын эх, Өргөн ширэг, Тэгш, Дунд шарын голоос эх авсан Булгын эх, Хотно, Цагаан байшин, Зах, Урд шарын голоос эх авсан Урд гол болон Баянгол, Элсэн бөөрөг зэрэг олон гол горхи, булаг, шандууд Шаргын голд нийлнэ.

Хасагт хайрхан уул нь далайн төвшнээс дээш 3578м өндөр, 1965 онд дархан цаазат газар болсон, талбайн хэмжээ 27448 га. Ховор ба нэн ховор буга, суусар, аргаль, янгир ирвэс, шилүүс зэрэг амьтан, мөн эмийн ургамал вансэмбэрүү, бамбай, гандигар, алтангагнуур, нэн ховор балга, зэрлэг сонгино, цагаан уул цэцэг, далин яргай, шинэс, хар мод бургас г.м ургамлууд бий.

Мөн байгалийн өвөрмөц тогтоц бүхий **Хүрхрээ**: Дэлхийн дотоод хүчний нөлөөгөөр үүссэн 10 м өндөр, 5-6 м өндөр урсгалтай, 35-45 км урт нарийн гүн хавцал юм.

Цагаан элс: Говийн олон жилийн салхинд туугдан хуримтлагдсан 7-8 ш тус тусдаа цувран тогтсон элсэн манхан Шаргын голынхоо баруун талд оршино. Өндөр 6-7 м нарийн торгон элс.

Аялал зуулчлалын чиглэлийн маршрут:

- Сумын төв- Хүрхрээ 40 км
 - Хүрхрээнээс – Морь харайдаг
 - Морь харайдаг- Их булгийн ам 36 км
 - Их булгийн ам- Тахилгат 10 км
 - Тахилгат-Гурван богдын үзэсгэлэнт газруудад явган аялал хийж танилцана.
 - Тахилгат- тээрмийн ам / тээрмийн чулуу үйлдвэрлэж байсан газар/ дэлхийд нэн ховордсон ургамлын төрөл болох Монголд 2 газар ургадаг Балга гэдэг модыг үзэх 32 км
 - Тээрмийн ам- Хойт шарын ам /чацарганы талбай- бүтээн байгуулалт 35 км /
 - Хойт шарын ам- Шарга 35 км

Аялал жуулчлалын SWOT шинжилгээ:

Давуу тал

Сул тал

- | | |
|---|---|
| <ul style="list-style-type: none"> • Байгалийн үзэсгэлэнт газруудад түшиглэн явган аялал, морин аялал болон авто аяллыг хөгжүүлэх боломжтой. • Сумын төвийн дээд болон урд чиглэлд төв замын чиглэлтэй. • Нутгийн брэнд бүтэгдэхүүн /ингэний ундаа, гүүний саам/ | <ul style="list-style-type: none"> • Тогтсон үйл ажиллагаагаа явуулж байгаа жуулчны бааз байхгүй • Зам тээвэр хөгжөөгүй • Цахилгааны асуудал хүндрэлтэй. |
|---|---|

Боломж

Саад бэрхшээл

- | | |
|---|--|
| <ul style="list-style-type: none"> • Дархан цаазат - Хасагт хайрхан уул болон Дунд шарын амны хүрхрээний чиглэлд авто аялал • Рашаант - Цагаан элсний чиглэлд явган аяллыг хөгжүүлэх боломжтой. | <ul style="list-style-type: none"> • Хөрөнгө санхүүгийн • Цаг агаарын эрс тэс уур амьсгал /хэт их халах/ |
|---|--|

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ

Тулгамдаж буй асуудлууд

Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд

- **Жуулчны бааз байгуулах хөрөнгө санхүү байхгүй.** Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр сумд бодитой ажлыг хийж хэрэгжүүлэн жуулчны баазыг байгуулах
- **Цахилгааны эх үүсвэр**

Хөдөө аж ахуйн салбар:

Манай сум 4 багтай, 1947 хүн амтай, мал аж ахуйн салбарыг голлон эрхэлж, энэ салбарт 382 өрхийн 861 малчид ажиллаж, нийт хүн амын 44,2 % нь мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байна.

Сумд 2013 оны жилийн эцсээр 106546 мал тоологдсон байна. Үүнээс тэмээ-3820, адуу-3525, үхэр-3028, хонь 20658, ямаа 75515.

2013 онд 45854 толгой хээлтэгч мал төллөж, 35398 төл бойжуулан 100 эхээс 77,2%-иар төлөө бойжуулан, оны эцэст 106546 толгой мал тоолуулж, мал сүргээ 5 төрөл дээр нь өсгөж, өмнөх оныхоос 13648 толгой малаар буюу 14,7%-иар өсгөсөн байна.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж, оны эхний ашиг шим өгвөл зохих 66002 ямаанаас 19,4 тн ноолуур, 3596 тэмээнээс 18,9 тн ноос, 17103 хониноос 26,2 тн ноос, ноолуур тус тус ашиглаж, нэг ямаанаас 295 грамм ноолуур, тэмээнээс 5260 грамм ноос, хониноос 1535 грамм ноос ашигласан байна.

Сумын хэмжээнд 2013 онд мал аж ахуйн ноосон бүтээгдэхүүнээс 1380700000 төгрөгийн орлоготой үйл ажиллагаа явуулсан байна.

Мөн газар тариалангийн салбарт 2013 онд 42 өрхийн 90 гаруй тариаланч ажиллаж 60 га талбайг боловсруулан үр тариа 15 га, төмс 20 га, хүнсний ногоо 15 га, тэжээлийн ургамал 2 га, жимс жимсгэнэ 8 га-д тус тус тариалалт хийж, 10 тн үр тариа, 130 тн төмс, 60 тн хүнсний ногоо, 6 тн тэжээлийн ногоон ургамал, 2тн чацаргана тус тус хураан авч, борлуулалт хийж, өрхийн орлогоо нэмэгдүүлсэн байна.

Хөдөө аж ахуйн салбарын SWOT шинжилгээ:

Давуу тал

Сул тал

- Манай сум нь 1800 га хадлангийн талбайтай, улс аймгийн нөөцийг жил бүр бүрдүүлдэг
- Мал аж ахуй, газар тариалангийн салбарт сүүлийн үед ажиллагсдын тоо буурч байна

Боломж

Саад бэрхшээл

Мөн мал аж ахуй, газар тариаланг хослон хөгжүүлж, тэжээлийн цех байгуулж, ажлын байр нэмэгдүүлэх

- -Туслах аж ахуйг хөгжүүлэх

- Хөдөө аж ахуйн салбарт хүний нөөц дутагдалтай байна.

Ялангуяа хөдөөд залуу малчид , тариаланчдыг төр засгаас бодлогоор зохицуулах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд

Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд

Ажилгүй залуучуудыг мал аж ахуй, газар тариалангийн ажилд татан оролцуулах

Төр засгаас мал аж ахуй, газар тариалан эрхлэгчдийн талаар бодлого боловсруулж урамшуулал болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх

-ХАА-н техник, тоног төхөөрөмжийн хангалт *-Урт хугацааны хөнгөлттэй зээл олгох*

Баянгол баг:

Баянгол багийн товч танилцууга

Халхын Засагт хан аймгийн Сүжигт гүний хошуу гэж 1755 онд одоогийн Шарга сумын Дунд шарын голын шар ямаатын бэлчирт суурьшжээ. 1959 онд Шарга сумыг Хасагт жаргалан сумаас таслан сумын төвийг Хойт голоос нүүлгэн Баянголын аманд суурьшуулсан болой. Галдан бошигтын дайны хөлөөр баруун Монголын нутагт тархан суурьшсан Ойрод буюу Өөлд Хойд овгийнхон тус сумын Баянгол нутгаар зонхилдог гэж хэлж болно. 1960 оны намрын эхэн сард Баянгол баг үүсгэн байгуулагдсан түүхтэй. Багийн Засаг даргаар ажиллаж байсан хүмүүсийг дурьдвал Ж.Хүрлээ, Н.Очирбат , Г.Гантулга, Н.Содной нар юм. Баянгол багийн бэлчээр нутаг нь 139,146.25 га талбайтай бөгөөд булаг, шанд, гол горхи, худгаар усны нөөцөө бүрдүүлдэг. Залгаа сум, багууд Хамтын хүч, Сондуулт, Улаан туг, Халиун сумын Олон булаг, Төгрөг сумын Тунгалаг, Өгөөмөр багуудтай хил залгаа нутагладаг.

2014 оны байдлаар 239 өрх, 812 хүн ам бүртгэгдсэн байна.

Малын тоо: Тэмээ 2767, адуу 1557, үхэр 1946, хонь 2870, ямаа 16790 Бүгд 25930.

Баянгол багийн СВОТ шинжилгээ

Давуу тал

Сул тал

Багийн нийт өрхийн дийлэнх нь сумын төвд суурьшсан, сумын төв байнгын гэрэл цахилгаантай, харилцаа холбоо сайн хөгжсөн байдаг

Худаг усны асуудлаас болж ,малын бэлчээр бүрэн ашиглаж чадахгүй байна.

Таван хошуу мал маллах боломжтой, газар тариалан эрхэлдэг,

Боломж

Саад бэрхшээл

Газар тариалан хөгжүүлэх, Ингэний сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Цөлжилт , элсний нүүдэл ихтэй

Багт өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх

Газрын гарц муу байна.

Тулгамдаж буй асуудал

Шийдвэрлэх арга зам

Баруун голын хулсанд чоно их хэмжээгээр үүрэлсэн байна.

Мод тарьж, баруун голын усыг баруун талруу явуулах

Газар, тариалан эрхлэдэг хүмүүсийг дэмжиж ажилах

Залуучуудад мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр сургалт хийх, дэмжиж ажилах

Хамтын хүч:

Анх 1954 онд Овоот сумын Алаг өндөр баг нэртэй байгуулагдаж, улмаар 1960 онд Шарга сумын Хамтын хүч бригад гэж нэрлэгдсэн түүхтэй. Анхны багийн даргаар Б.Довдон гэдэг хүн ажиллаж байсан. Үүнээс хойш ажиллаж байсан багийн дарга нарыг дурьдвал: Н.Нямхүү, С.Бариад, Г.Юндэн, П.Ядам, Х.Сүрьеэ, П.Мягмаржав, Д.Пүрэв, Д.Ээсэн, С.Ням Осор, Б.Бөхчулуун, Э.Тодхүү, А.Цогбадрах, Д. Ичинхорлоо, Б.Гантай нар болно. Хамтын хүч багийн бэлчээр нутаг нь 488758.2га талбайтай бөгөөд ихэвчлэн худгаар усны нөөцөө бүрдүүлдэг. Залгаа сум багууд Дарви сум Жавхлант баг , Баян уул сум Хүйсийн говь баг, Шарга сумын Сондуулт, Баянгол багуудтай хиллэдэг болно.

Багт 2014 оны байдлаар 112 өрхийн 378 хүн ам бүртгэгдэж, мал аж ахуйгаар өрхийн орлогоо бүрдүүлж байна.

Хамтын хүч багийн SWOT шинжилгээ

Давуу тал

Сул тал

➤ Харилцаа холбоо хөгжсөн

➤ Бэлчээрийн усан хангамж муу

Байгалийн нөөц баялаг ихтэй

➤ Ундны ус хатуулаг ихтэй

Боломж

- Баруун бүсийн төв замыг түшиглэн иргэд болон баг хөгжих

•

Саад бэрхшээл

- Бэлчээрийн усан хангамж дутмаг, бэлчээрийн доройтол учраас мал өсгөн үржүүлэхэд бэрхшээлтэй

Тулгамдаж буй асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд

Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд

Бэлчээрээ бүрэн ашиглах боломжгүй

Худаг ус гаргах

Бэлчээрийн доройтол

Үлийн цагаан оготно устгах

Байгалийн баялаг устаж, унаган төрх алдагдаж байгаа

Уул уурхайн ашиглалт явуулахгүй байх

Сондуулт баг:

Засагт хан аймгийн Сүжигт гүний Хошуу буюу одоогын Шарга сумын нутагт 1958-1959 оныг хүртэл “ Шар тал ” баг нэртээ байж байгаад 1960оны 9 дүгээр сарын 01 нд одоогийн Сондуулт баг байгуулагдсан түүхтэй. Анхны багийн засаг даргаар нь Луузан – Альва дараах багийн даргаар Х.Бадарч тоо бүртгэгч Б. Батжав нар анхдагчаар нь ажилаж байсан .Түүнээс хойш багийн засаг даргаар ажиллаж байсан хүмүүсийг дурдвал **Г.Буриад, Х.Бадарч, Б.Дүгэржав, Г.Юндэн, Ю.Гиваапил, М.Цагаан, У.Алтангэрэл, Д.Батбаатар, Б.Батжав, Б.Бөхчулуун, В.Цоодол, Б.Жамъяндорж, Х. Даваацэрэн, Ц.Даваадорж** нар юм. Сондуулт баг нь Бэлчээр нутаг нь 128340 га талбаатай бөгөөд булаг шанд гол горхи нийлсэн 20 гаруй 32 худагаар цэвэр усны нөөцөө бүрдүүлдэг. Залгаа сум багууд Баян уул сумын Чандмань хайрхан, Баян хайрхан, Хүйсийн говь баг, Жаргалан сумын Тээлийн гол баг, Өөрийн сумын Улаан туг, Баянгол, Хамтын хүч зэрэг багуудтай хиллэдэг.

- 2014 оны байдлаар 92 өрх 329 хүн ам бүртгэгдэж, мал аж ахуйгаар өрхийн орлогоо бүрдүүлж байна.

Тэмээ 217 толгой

- Адуу 314 толгой
- үхэр 411 толгой
- Ямаа 4367 толгой
- Хонь 13514 тогой
- нийт мал 18823 толгой

Сондуулт багийн SWOT шинжилгээ

Давуу тал

Манай багийн нутгаар баруун бүсийг холбосон төв зам дайран өнгөрдөг мөн баруун бүсийн замын төв зангилгаа “ээвийн” буудал байрладаг бөгөөд Мөн дархан цаазат Хасагт хайрхан уул байрладаг.

Боломж

- Байгалийн үзэсгэлэнт газрыг түшиглэн аялал жуучлалын газар байгуулах
- Баруун бүсийн төв замыг түшиглэн иргэд болон баг хөгжих

Сул тал

- Сумын төвөөс 70 км алслагдсан
 - Цас их унасан жил зам хаагдаж Сумын төв болон харъяа багуудаас тусгаарлагддаг

Саад бэрхшээл

- Намрын отрын нутагт усны асуудал шийдвэрлэх
- Уул уурхайн болон гар аргаар алт олборлогчид онгон байгалийг хөндөж бэлчээр нутгийг сүйтгэж байна.
- Үлийн цагаан ихсэж бэлчээр сүйтгэж байна.

Тулгамдаж буй асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд

Бэлчээрийн усан хангамж муугаас огт ашиглалтгүй бэлчээр их болж байна

- Бэлчээрийн доройтол ихэссэн
- Гар аргаар алт олборлосноос малын бэлчээр устаж байна

Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд

- Отрын бүс нутагт худаг ус гаргах
- Үлийн цагаан оготно устгах
- Нөхөн сэргээлт хийх

Улаантуг баг

УЛААН ТУГ БАГИЙН ТАНИЛЦУУЛГА

Засагт хан аймгийн Сүжигт гүний хошуу одоогийн Шарга сумын нутаг Дунд шарын голыг дагаж Шар ямаатын бэлчир /Өвгөн хүрээ ч гэдэг/, Батхайрханы /одоогийн Алагхайрхан/ өвөрт төвлөрч байсан нь түүхэн баримтаар үлдсэн байдаг. Сүжигт гүний хошууг нэгэн үе Батхайрхан уулын хошуу хэмээн нэрлэж хошууг хамгийн сүүлд Цэрэнчагдаржав захирч байсан байна. Ардын засгийн газраас хошууны ардыг хуралдуулж Батхайрхан уулын хошууг татан буулгаж Батхайрхан сумыг шинээр байгуулж, Алаг хайрханы өвөрт төвлөрүүлж, сумын МАН, МХЗЭ-ийг анх байгуулж байжээ. 1959 оны 12-р

сард тухайн үеийн Хасагт жаргалан сумаас Шарга сумыг таслан Баянголын аманд суурьшуулахад Хасагт жаргалан сумыг Одоогийн Улаан туг багийн Дунд шарын аманд төвлөрүүлсэн байдаг. 1956 онд партизан Г.Балжинням санаачлан Улаан туг нэгдлийг байгуулсан нь тус багийн үүсэл хөгжил тавигдсан гэж үзэж болох юм.

Анхны даргаар Ж.Норов ажиллаж байсан. Баг бригадын даргаар ажиллаж байсан хүмүүс /Б.Дүгэржав, Б.Бүрэнтөгс, Ю.Гиваапил, Д.Уданбор, Г.Юндэн, П.Орос, Намжигдорж, Б.Батжав, В.Цоодол, Р.Банзрагч, Б.Бөхчулуун, Х.Бат-Очир, Ш.Даваабал, Н.Батсайхан, Ц.Мижиддорж, М.Доржсүрэн, С.Мөнхням, А.Алтангэрэл/

Улаан туг баг нь 129 мянган га бэлчээр нутагтай, 123 өрхийн 428 хүн амтай. Зүүн талаараа Жаргалан сумтай, Зүүн урд талаараа Тайшир, Есөнбулаг сумтай, баруун урд талаараа Халиун сумтай, баруун талаараа өөрийн сумын Баянгол багтай, хойд талаараа Сондуулт багтай хиллэдэг.

2014 оны байдлаар 123 өрх, 428 хүн ам бүртгэгдэж, мал аж ахуйгаар өрхийн орлогоо бүрдүүлж байна. Малын тоо – 31942.

Улаантуг багийн SWOT шинжилгээ

Давуу тал

Зах зээлдээ ойрхон.түүхий эдээ өндөр үнээр борлуулж, өргөн хэрэглээгээ хямдаар хангах боломжтой.

Байгалийн өвөрмөц онцлог нь аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой

Бэлчээр нутаг нь таван хошуу малын зохистой байршил болдог.

Гадаргын усны нөөц ихтэй усалгаатай газар тариалан эрхлэх бүрэн боломжтой

Алтай Ховдын чиглэлийн улсын чанартай зам дайран өнгөрдөг.

Олон төрлийн байгалийн баялагтай

Боломж

- Аймгийн төвд ойрхон
- Сумдаа малын тоо толгойгоороо тэргүүлдэг

Сул тал

Зам харилцаа муу

Хүн ам цөөн

Шилжих хөдөлгөөн их

Саад бэрхшээл

- Аймгийн төвд байнгын оршин сууж байгаа өрхийн тоо их

Тулгамдаж буй асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд

- Сумын хадлангийн талбайд тус багийн эзэмшлийн 50 га газрын ашиглалтыг сайжруулж эргэлтэнд оруулах,
- Аймгийн төвтэй ойрхон давуу талаа ашиглаж эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан хослуулан хөгжүүлэх
- Мал эмнэлэг үржил үйлчилгээний нэгжийг бэхжүүлэх, материаллаг баазыг сайжруулах
- Малын үүлдэр угсааг сайжруулах, сүргийн зохистой харьцааг бүрдүүлэх
- Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах
- Бэлчээрийн ашиглалтыг сайжруулах
-

Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд

- Хадлан, газар тариалангийн чиглэлээр техник хэрэгсэл нийлүүлж, хоршоо нөхөрлөл байгуулж хамтын хөдөлмөрийн давуу тал бий болгох
- Мал эмнэлэг үржил үйлчилгээний нэгжийг бэхжүүлэх, материаллаг баазыг сайжруулах
- Багийн төв барих
- Намрын отрын бүсэд 2-3 гүн өрмийн худаг гаргах

Мал эмнэлэг үржил үйлчилгээний нэгжийг бэхжүүлэх, материаллаг баазыг сайжруулах

Шарга сумын дэд бүтцийн салбарын хөгжил: **Ерөнхий мэдээлэл:**

А.Хатуу дэд бүтцийн хөгжил

Замын нөхцөл байдал:

Манай сум улсын нийслэлээс 1087 км-т оршдог. Үүнээс одоогоор 690 км нь хатуу хучилттай, 397 км нь сайжруулсан шороон замаар холбогдсон байна. Аймгийн төвөөс 87 км-ийн зайтай.

Баруун чиглэлийн Ховд, Увс, Баян-Өлгийн хот хоорондын авто зам сумын төвөөс 15 км-ийн зайтай 3 багийн нутгийг дайран өнгөрдөг. Сум 4 багтай сумын төв нь Баянгол багийнхаа нутаг дэвсгэр дээр оршдог. Хамтын хүч баг буюу сумын хойд талын баг 50-70 км-ийн зайтай, Сондуулт баг буюу зүүн хойд зүүн талын баг сумаас 45-60 км-ийн зайтай, Улаан туг баг буюу аймгийн төвтэй залгаа баг зүүн урд талын баг сумаас 55-80 км-ийн зайд оршдог. Багуудын зам уулын хярдаа зам нь бартаатай, хад чулуу ихтэй.

Сумд бүхэлдээ шороон замтай.

Цахилгаан эрчим хүчний хангамж:

Шарга суманд эрчим хүчний салбар анх 1957 онд байгуулагдан, МААМ станцын харъяанд ДС- 50 дизель станц- 1 ш суурилагдаж, механикаар Билэгт, моторчин цахилгаанчнаар Баашлав, Очиржав нар ажиллаж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.

1967 онд МААМ станци татан буугдаж дизель станц Говийн хөгжил нэгдлийн мэдэлд очиж, 1978 онд тус сум орон нутагт ХАА-н ТМС болон бусад үйлчилгээний цэг салбарууд байгуулагдан ажиллаж 300 орчим айл өрх суурьшиж, гэрэл цахилгааны хэрэглээ ихэссэнээр техникийн парк шинэчлэлт хийгдсэн.

Шинээр ДГА- 200 дизель станц – 2 суурилагдаж Говь- Алтай аймгийн Эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн харъяа Шарга сумын эрчим хүчний салбар нэртэй үйлдвэрлэл үйлчилгээг 24 цагийн турш явуулсан.

1989 онд техникийн парк шинэчлэлт хийж ДГА- 315 дизель станц суурилагдсан.

1994 онд гэрэл цахилгааны хэрэглэгч цөөрч ,түлш шатахууны үнэ өсч, орон нутгийн эдийн засгийн боломж нөхцлөөс шалтгаалж ДГА- 200, ДГА- 315 дизель станцуудын үйл ажиллагааг зогсоож , жижиг дизель станц болох ДДА-100, ЯМЗ- 238, /100/ дизель станцуудыг авч орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн хэлбэрээр засаг даргын тамгын газрын харъяанд үйл ажиллагаа явагдаж эхэлсэн.



2001 онд хуучин барилгад ажилчдын хүчээр засвар хийж, Япон улсын тусламжаар ирсэн 2 дизель станцыг хүлээн авч суурилуулан сумын төвийн цахилгаан эрчим хүчний хэрэгцээг хангаж ажилласан.

2010 оны 9-р сарын 01- нээс эхлэн Алтай-Улиастай ТӨХК-ий мэдэлд өмч хөрөнгө шилжсэнээр одоо ахлагч цахилгаанчин М.Пүрэвдорж, өндрийн монтёр Э.Тогтбаатар, Б.Саруулбуян, байцаагч монтёр Б.Цогпүрэв гэсэн 4 орон тоотойгоор Оросын холбооны улсаас 35/15 кв-ын өндөр хүчдэлийн шугам сүлжээгээр хүчдэл авч 24 цагийн үйлдвэрлэл үйлчилгээг байгууллага иргэдэд хүргэж байна.

Дулааны эрчим хүчний хангамж:

Сумын дизель станц татан буугдсанаар 1992 оноос уурын зуух ажиллахаа больж, төсөвт 5 байгууллагууд нам даралтын халаалтын системтэй болсон байна. Газар доогуурх шугам сүлжээ үндсэндээ устаж, уурын зуухны 2 барилга үлдсэн байдаг.

Зураг

Холбоо, мэдээллийн сүлжээний хөгжил:

Цахилгаан холбоо Олон сувгийн тоон техникийн системийг 2001 оны 5-р сард нарны зайг 2003 оны 03-р сард улс хоорондын бүрэн автомат холбоогоор харилцдаг болжээ. Одоогийн байдлаар 6 сувгийн антеннаар хэвийн үйл ажиллагаа явуулж байна. Сумын Холбооны салбарын эрхлэгчээр Ойдовын Зинээзэг ажиллаж байна.

2005 он хүртэл сумын түвшинд ажилласан. Одоогоор 1 хүнтэй ажилладаг. Сумд 4 үүрэн телефоны сүлжээ орсон байдаг. Мобиком 2005 онд, Жи мобил 2008 онд, скайтел 2009 онд, юнител 2012 онд тус тус орсон байна.

Шуудан холбоо хэвлэлийн захиалга үйлчилгээг үзүүлж байна.

Шатах, тослох материалын хангамж:



Сумын хэмжээнд хувийн хэвшлийн 3 шатахуун түгээх станц ажиллаж ард иргэд, албан байгууллагуудад А-80 бензин, дизель түлш болон бусад тос, тослох материалын худалдаа үйлчилгээг эрхэлж байна. Сумын төвд “Мон суль” ХХК, Сондуулт багийн Далан ээвд “Гүн зэгэстэй” ХХК, Баянгол багийн Заг овооны гүүрэнд “Магнай трейд” ХХК-ий салбар нэгжүүд ажиллаж байна.

Хэрэглээний болон ундны усны хангамж:

Сумын төвийн хэрэглээний усан хангамж сайтай. Сумын төвөөс баруун урагш 1км-т газрын гүнээс гардаг харз булагтай, гүний 3 худаг ажиллаж, цахилгаан насосоор 16-120 м-ийн гүнээс усаа татаж байдаг. ЗДТГ-ын худаг 1990 онд шинэ насос суурилуулсан, цагаан худаг 2002 онд шинэ тоног төхөөрөмжөөр засварлагдаж, 2007 онд Орон нутгийн засаглалыг дэмжих төслийн 2.0 сая төгрөгөөр, 2011 онд Алтай хөгжил XXI зуун ТББ-ын 700.0 мянган төгрөгөөр, 2013 он д Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр иргэдийн бүлэг 10.0 сая төгрөгний ган чайнь нийлүүлж, гадна дотно засварыг хийсэн байна.




Барилга, хот байгуулалт

Сургуулийн дотуур байр 1980 оны барилга 2012 онд 80 сая төгрөгөөр засварлагдсан, хичээлийн байр 1978 оны барилга 2005 онд их засварт орсон, ахуй үйлчилгээний байр 1959 онд ашиглалтад орж 2010 онд 39 сая төгрөгөөр засварлагдсан. Багш нарын 4 айлын орон сууц 1978 оны барилга, ЗДТГ-ын байр 1959 оны барилга хамгийн сүүлд 2007 онд их засварт орсон, зочид буудал 1958 онд ашиглалтад орж одоогоор ашиглах боломжгүй гэсэн дүгнэлттэй албанд ашиглагддаггүй, цагдаагийн кабон 1958 оны барилга, ЗДТГ-ын өргөтгөлийн цагаан байр 1990 оны нэгдлийн конторын зориулалтаар баригдсан байна.

Хүүхдийн цэцэрлэг 1958 оны барилга 2005 онд их засварт орсон, Соёлын төв 1962 оны барилга хамгийн сүүлд 2013 онд 80 сая төгрөгөөр засварлагдсан. Номын сангийн барилга 1968 онд ашиглалтад орж, 2014 онд актлагдаж байгаа. Хүн эмнэлгийн барилга, эхчүүдийн амрах байр 1980 онд ашиглалтад орж, 2010 онд их засварт орсон. Эрчим хүчний барилга 1978 онд баригдсан, Холбооны барилга 1968 онд баригдсан барилга байна.

Газар зохион байгуулалт



Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал, газар ашиглалтын төрөлд гарсан өөрчлөлт, шилжилтийн байдлыг авч үзвэл тус сум нь нийт **556585,0** га нутаг дэвсгэртэй бөгөөд 2011 онд Хөдөө аж ахуйн газар **491576.0** га, Хот тосгон бусад суурины газар **350** га, Зам шугам сүлжээний газар **433** га, Усан сан бүхий газар **1765** га, Ойн сан бүхий газар **49502** га газрыг тус тус эзэлж байгаа бөгөөд 2010 оны нэгдмэл сангийн тайлангийн дүнтэй харьцуулахад бэлчээрийн

газар **9.1** га-аар буурч, барилга байгууламжийн газар **0.5** га-аар нэмэгдэж, гэр хорооллын газар **0,4** га-аар нэмэгдэж бусад ангиллын газарт өөрчлөлт гараагүй байна.

Хатуу дэд бүтцийн SWOT шинжилгээ

<i>Давуу тал</i>	<i>Сул тал</i>
<ul style="list-style-type: none"> • Аймгийн төвд ойрхон • Баруун чиглэлийн авто зам дайран өнгөрдөг • 35квт-ийн өндөр хүчдэлийн шугам сүлжээтэй. • Сумын усан хангамж, усны чанар сайн • Баруун 4-5 сумуудын зам дайран өнгөрдөг 	<ul style="list-style-type: none"> • Зам харилцаа хөгжөөгүй • Хөдөө багууд алслагдмал • Нийслэлээс алслагдсан • Интернетийн сүлжээгүй
<i>Боломж</i>	<i>Саад бэрхшээл</i>
<ul style="list-style-type: none"> • Нийслэлтэй хатуу хучилттай замаар холбогдох боломжтой • Цахилгааны найдвартай эх үүсвэрээр хангагдсан • Хэрэглээний усан хангамж сайн • Үйлдвэр үйлчилгээ, аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой 	<ul style="list-style-type: none"> • Сумын 2 баг нь аймгийн төвд суурьшсан • Барилгуудын насжилт өндөр • Инженерийн шугам сүлжээ устаж үгүй болсон • Түлшний хангамж муу
Тулгамдаж буй асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:	
<p>Тулгамдаж буй асуудлууд</p> <p>Алслагдсан бүс нутаг учраас амьжиргааны өртөг өндөр Хэтийн хөгжлийн бодлого, зураглалгүй</p> <p>Иргэдийн ая тухтай амьдрах орчин бүрдээгүй</p>	<p>Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд</p> <p>Зам харилцааг сайжруулж, УБ хот, аймгийн төвтэй хатуу хучилттай замаар холбогдох Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөлтийг ойрын хугацаанд гаргах</p> <p>Төвлөрсөн дулааны шугам сүлжээтэй болох</p>

Б.Зөөлөн дэд бүтцийн хөгжил**Банк, санхүүгийн үйлчилгээ:****Шарга сумын ХААН банк**

Тус сумын банкны салбар анх 1975 оны 04-р сараас Говийн хөгжил нэгдэлд тооцооны касс нэртэйгээр банкны йл ажиллагаа эхлүүлсэн. 1993 оноос ХАА-н банк болон ерэгжиж, хадгаламж касс зээлийн йл ажиллагааг нэвтрүүлсэн. 2002 оны 03 сараас хувьд шилжин ХААН банк болж өнөөдрийг хиртэл санхүүгийн бйх терлийн бйтээгдэхийнээр ййлчлэн ажиллаж байна.



Зййн гараас Эдийн засагч

Т.Туул, Эрхлэгч Н.Цогзолмаа , Теллер Б.Слзийбаяр.



2007 онд анх Монгол Шуудан банк нэртэй байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

2013 оноос Төрийн банкны харъяа Шарга тооцооны төвд захирал П.Бямбадулам, Ахлах теллер Б.Тайванбаатар, Теллер Н. Нямбаатар нар ажиллаж байна.

**Төр, бизнес, иргэний нийгмийн түншлэл, хамтын ажиллагаа:**

Тус сумд Морин спорт уяачдын холбоо, Ахмадын холбоо, Залуучуудын холбоо, Эмэгтэйчүүдийн зөвлөл, Шийдвэр гаргах түвшний эмэгтэйчүүдийн холбоо, Үйлдвэрчний эмлэлийн холбоо зэрэг төрийн бус байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна.

Зөөлөн дэд бүтцийн SWOT шинжилгээ*Давуу тал*

- Ард иргэд мэдээ мэдээллээр хангагдах мэдээллийн олон сувагтай
- Төрийн бус байгууллагууд үйл ажиллагаа явуулдаг
- Газарзүйн байршлын хувьд дэд бүтэц хөгжих бүрэн боломжтой

Сул тал

- Банк санхүүгийн өрсөлдөөн бага
- Иргэдийн өөрийгөө хөгжүүлэх идэвх оролцоо сул
- Хэрэглэгч багатай
- Эдийн засгийн чадавх сул

Боломж

- Банкны шинэ салбар, банк санхүүгийн төрөл бүрийн байгууллага бий болох боломжтой
- Цахилгаан эрчим хүч, мэдээлэл холбоо сайн хөгжсөн
- Боловсон хүчний хангалт сайн

Саад бэрхшээл

- Иргэдийн амьжиргааг дээшлүүлэх арга зам хүнд
- Ажлын байр дутмаг
- Банк санхүүгийн байгууллагын хараат

Тулгамдаж буй асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
Банкны хүү, нөхцөл өндөр	Шинээр Голомт, Капитрон, Хас банкны салбарыг оруулах Барьцаалан зээлдүүлэх санхүүгийн байгууллагыг бий болгох
Иргэдийн хамтран ажиллах, хөгжих чадвар сул	Иргэний нийгмийн байгууллагуудыг олноор бий болгох
Иргэдийн худалдан авах чадвар сул	Өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, МАА, газар тариалан эрхлэгчдийн тоог нэмэгдүүлэх
Иргэдийн хуулийн мэдлэг дутмагаас хохирох талтай	Хууль эрх зүйн туслалцааны төвтэй болох

Нийгмийн үйлчилгээний салбарын хөгжлийн байдал

Хүн ам зүй

Хүн амын үзүүлэлтүүд



2013 оны жилийн эцсийн статистик мэдээнээс үзвэл:

565 өрхөд 1947 хүн амьдарч байгаа ба нэг өрхөд дунджаар 3 хүн амьдарч байгаа нь улсын дундажаас багавтар байна. Сумын нийт хүн амын 47,8% нь эмэгтэй, 52,2% ийг эрэгтэйчүүд эзэлж байна. Өрх толгойлсон эмэгтэй 101, эрэгтэй 43.

Хүн амын насны бүтцээр нь авч үзвэл 0-16 насны хүүхдүүд 31.1 %, 16-35 насны залуучууд 32,3 %, 36-54 насны идэрчүүд 26,02% , 55-с дээш насны ахмад 10.47 %-ийг тус тус эзэлж байна.

Шилжилт хөдөлгөөн

Сүүлийн 6 жилийн дунджаар жилд 52 хүүхэд төрж, 14 хүн нас барж жилд дунджаар 3 хүнээр өссөн байгаа нь 1990-ээд онтой харьцуулбал төрөлт багасч байна. Сүүлийн жилүүдэд төрөлт ялимгүй өссөн байна. Энэ нь нийгмийн халамжийн үйлчилгээтэй холбоотой гэж үзэж байна. 2013 онд жилд 105 хүн шилжин явж, 69 хүн шилжин ирсэн ба жил бүр шилжин ирсэн хүнээс шилжин явсан хүний тоо 20-30 хүнээр илүү байдаг. Шилжилт хөдөлгөөн ихэсч байгаа нь дэд бүтэц хөгжөөгүй, аймгийн төвтэй ойр болон улсын нийслэлээс хэт алслагдсантай холбоотой гэж үзэж байна.



Хүн ам зүйн байдлын SWOT

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
Айл өрхийн хаягжуулалт байхгүй	Сумын 90 жилийн ойн ажлын хүрээнд бүх айл өрхийг хаягжуулах
Хаягийн зөрчилтэй иргэн ихтэй	Хаягандаа байхгүй иргэдийн хаягийн зөрчлийг арилгах
Интернэтийн орчин хязгаарлагдмал	Шилэн кабель оруулж интернэт кафе бий болгох.
Залуучууд чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин бүрдээгүй	Гэгээрлийн өргөө болон, соёл спортын цогцолбор байгуулах.
Ажилгүйдэл их, ажлын байр бага.	Уул уурхай, газар тариалан, хадлан тэжээлийн талбайг түшиглэн ажлын байр нэмэгдүүлэх.

Залуу гэр бүлийг сум орон нутагтаа татан суурьшуулах

Дэд бүтцийг цогцоор нь хөгжүүлэх

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд

Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд

Хаягандаа байхгүй хүн ам ихтэй./Улаан туг, сондуулт баг/

Байгалийн эрс тэс уур амьсгалаас болж, зүрх судас, шээсний замын өвчлөл их

Эрүүл аж төрөх зөв дадал хандлагыг иргэдэд төлөвшүүлэх сургалтыг зохион байгуулах

Газар нутгийн хувьд 2 баг нь аймагт ойрхон учир Улаан туг Сондуулт багийн иргэд сумдаа төрийн үйлчилгээнд хамрагддаггүй.

Төрийн бодлого зохицуулалт хэрэгтэй.

Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ:

Шарга сумын хүүхдийн цэцэрлэг нь 1959 онд анх мал аж ахуйн машинист станцыг түшиглэн 3 ажилчин 25 хүүхэдтэйгээр одоогийн сумын зочид буудалд ажлаа эхэлж байсан байна. Одоо 11 ажилчинтай үндсэн сургалтаар 70 гаруй хүүхэд, хувилбарт сургалтаар 40 –өөд хүүхдэд буюу тойргийн нийт хүүхдийн 84 %-д сургуулийн өмнөх боловсрол олгож байна. Сургалтын таатай орчин материаллаг баазын хувьд бүрэн бэхэжсэн, үйл ажиллагаа тогтмолжсон бүтээлч хамт олон юм.



Сургуулийн өмнөх боловсролын SWOT:

Орчны үзүүлэлт

Давуу тал

Сул тал

Материаллаг

- Тохилог цэвэрхэн
- Халаалт найдвартай

- Цэцэрлэгийн байр багтаамж хүрэлцээ муу

орчин	<ul style="list-style-type: none"> • Төрөл бүрийн сургалт зохион байгуулах заал танхимтай • Зориулалтын байртай. 	<ul style="list-style-type: none"> • Хүүхдийн ор дэр хүрэлцээ муутай, элэгдэж хуучирсан • Бохирын шугам сүлжээ найдвар муутай. • Сургалтын тоног төхөөрөмж хуучирсан, хүрэлцээ муутай
Сэтгэлзүйн орчин	<ul style="list-style-type: none"> • Бүтээлч эвсэг хамт олон бүрдэж чадсан • СӨБ-ын мөн чанарыг ард иргэдэд ойлгуулсан • Эцэг эхийн дунд тогтмол сургалт явуулдаг, тэдний сэтгэл зүйд хүрч чадсан • Мэргэжлийн багшаар хангагдаж байгаа заах арга ур чадварт ахиц гарч байгаа • СӨБ-д хамран сургалт нэмэгдэж байгаа , хүүхдийг хамруулах тал дээр санаачлага гарган ажиллаж байгаа • Сургалтын орчин бүрдүүлэхэд ахиц гарч байгаа • Сум аймагтаа эхний байруудад шалгарч байсан 	<ul style="list-style-type: none"> • Багш ажилчдын ахуй амьдрал харилцан адилгүй өөр өөр байдаг • Зарим эцэг эхчүүд хүүхэддээ бага анхаарал тавьдаг, цэцэрлэгт хүүхдээ даатгадаг. • Сургалтыг шинэлэг байдлаар зохион байгуулах тал дээр эрэл хайгуул муу хийдэг, хүүхэд бүрийг хөгжүүлэх сургалтын технологийг бүрэн хэрэгжүүлж чадаагүй
Үйл ажиллагааны орчин		
Гадаад орчны үзүүлэлт	Боломж	Эрсдэл буюу саад бэрхшээл
Эдийн засгийн	<ul style="list-style-type: none"> • Хөрөнгө оруулалт хийх • Жижиг төсөл хэрэгжих • Зуны сургалт зохион байгуулах • Хүнсний ногоо 	<ul style="list-style-type: none"> • Багш ажилчдын цалин амьдрал ахуйд хүрэлцдэггүй • Хүүхэд цөөн учраас төсөв хүрэлцээ муу, материалын

	<ul style="list-style-type: none"> • тариалах • Хамрах хүрээг нэмэгдүүлэх 	<ul style="list-style-type: none"> • үнэ тогтворгүй байнга өсдөг
Өрсөлдөөн	<ul style="list-style-type: none"> • Бусад сумын цэцэрлэгүүдээс туршлага судлах боломжтой • Ажлын туршлагатай 	<ul style="list-style-type: none"> • Бага насны хүүхэдтэй ажиллахад өвөрмөц ур чадвар арга барил шаарддаг учраас шантарч, ажил мэргэжлээ солих явдал их гардаг • Өрсөлдөөн багатай
Нийгмийн	<ul style="list-style-type: none"> • Ойролцоо цэцэрлэгүүдтэй хамтран ажиллах • Сургуультай хамтран ажиллах • Эцэг эхчүүдтэй хамтран ажиллах 	<ul style="list-style-type: none"> • Хүүхдүүдийн амьдралын түвшин харилцан адилгүй • Аймагтай ойр учир шилжилт хөдөлгөөн ихтэй • Хүн ам цөөн аймагт ойр учир 2 баг нь аймагт төвлөрдөг.

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга зам

Тулгамдаж буй асуудлууд

Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд

Сургалтын таатай орчин бүрдүүлэх:

- Хүүхдийн тоглоомын талбайг орчин үеийн тоглоом наадмаар хангаж тохижуулах
- Хүүхдийн зөөлөн эдлэл, ширээ сандлыг шинэчлэх
- Цэвэр бохирын шугам сүлжээг нэгдсэн системд холбох
- Цэцэрлэгийн гадаа талбайд туршилт танин мэдэхүйн талбай байгуулан ажиллах
- Урлаг спортын заалны тоног төхөөрөмжөөр хангах
- Барилгын өргөтгөл их засвар хийх

- Хүүхдийн тоглоомын талбайг төсөл хандив тусламжаар 2014-2016 онд
- Хүүхдийн зөөлөн эдлэл, ширээ сандлыг улсын төсөв , төсөл хөтөлбөрөөр 2015-2016онд
- Инженерийн шугам сүлжээнд холбогдох
- 2015 онд байгууллагын ажилчдын, эцэг эхийн тусламж дэмжлэгтэйгээр
- Барилгын их засвар өргөтгөлийг улсын төсвөөр 2016-2017 онд

СӨБ ын үйлчилгээ:

- Малчдын хүүхдийн хамран

- Малчдын хүүхдийн хамран сургалтыг 60-80%-д хүргэх
- Эцэг эхийн сурган хүмүүжүүлэх мэдлэгийг дээшлүүлэх
- Явуулын багш ажиллуулах

Ур чадвартай багш боловсон хүчин:

- Багш нарыг сургалт семинарт хамруулах туршлага судлуулах
- Ажлын байранд мэдлэг боловсролоо дээшлүүлэх орчин нөхцөл, компьютер пректор болон бусад техник хэрэгслээр хангах
- Багш нарыг 80% нь зэрэгтэй болох
- Интернет болон дотоод сүлжээнд холбогдох

сургалтыг 2014-2019 онд

- Явуулын багш 2015 онд ажиллуулах
- багийн цэцэрлэг 2015-2016 он

- Багш нарыг жил бүр сургалтанд хамруулж мэдлэг боловсролыг дээшлүүлэх
- Багш бүрийг компьютер болон бусад тоног төхөөрөмжөөр хангах ажлыг хандив тусламж , улсын төсвөөр 2015-2019 онд
- Интернет болон дотоод сүлжээнд 2014 онд

Ерөнхий боловсролын үйлчилгээ:

МОНГОЛ УЛСЫН БААТАР МАГСАРЫН ЖАНЧИВЫН НЭРЭМЖИТ ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ШАРГА СУМЫН БҮРЭН ДУНД СУРГУУЛЬ

Тус сургууль нь анх 1936 онд Хантайшир уулын аймгийн Гурван сайхан уулын хошууны Батхайрхан сумын Сайн дурын сургууль нэртэйгээр захирал багш-1 галч-1 таван ханатай гэрт 23 сурагчтай анх байгуулагджээ.

2013-2014 оны хичээлийн жилд удирдах ажилтан 2, нийгмийн ажилтан 1, багш 17,

ажилтан 24, өдрөөр 220 суралцагч, дүйцсэн хөтөлбөрөөр 11 суралцагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Багш, удирдах ажилтны 42,1% магистрын боловсролтой, 76,4% нь багшлах эрхийн үнэмлэхтэй, 10.5% нь мэргэжлийн тэргүүлэх зэрэгтэй. Одоогоор тус сургуульд боловсролын тэргүүний ажилтан 3, хөдөлмөрийн хүндэт медальтан 3, Алтан гадас медальтан 1, ЗГ-ын жуух бичигтэн 3, аргагүйч багш 7, ахлах багш 4,



багшийн алдар медальтан 6 тус тус ажиллаж байна.

ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Дотоод орчны шинжилгээ	
Давуу тал /Strengths/	Сул тал /Weaknesses/
<ul style="list-style-type: none"> • Сургуулийн байршил оновчтой тохиромжтой • Мэргэжлийн багш нараар 100% хангагдсан • Багш нарын 80% нь сүүлийн 5 жилд мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан • Сургуулийн анги танхим хүрэлцээтэй • Сургалтын орчин үеийн техник хэрэгслээр зохих хэмжээнд хангагдсан • Сургуулийн хичээлийн байрны болон дотуур байрны халаалтын асуудал шийдэгдсэн. • Сургуулийн дотоод орчны үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн • Санхүүжих эх үүсвэртэй, төсвөө өөрөө захиран зарцуулах эрхтэй • Эцэг эх, суралцагчдын боловсролыг үнэлэх үнэлэмж нэмэгдсэн • Хамт олны төлөвшил сайн, ажилсаг • Суралцагчдын авъяас сонирхлын дагуу сонгон секц тогтмол хичээллүүлдэг. • АББ-ын төв ажиллаж сургалт явуулдаг • 	<ul style="list-style-type: none"> • Зарим сурагчдын гэрийн байршил сургуулиас хэт алслагдсан • Хүн амын шилжилт хөдөлгөөн ихэссэнээс хүүхдийн тоо цөөрч анги дүүргэлт багассан • Багш нарын нийгмийн асуудал хүндрэлтэй • ЗАН-ийн ажил тогтмолжоогүй • Гал тогооны газар зориулалтын байранд бус • Мэдээлэл хомс, хожуу мэдээлэл авдаг • АББ-д сумын төсвийн 1%-г төлөвлөдөггүй • СЦУЗ-ийн үйл ажиллагаа тогтмолжоогүй • Сургуулийн мэдлийн олон барилга байгууламжтай, түүнийг засварлахад хөрөнгө их шаардагддаг • Сургуулийн дотуур байр олон жил ашиглагдсан, шинээр барих шаардлагатай

Гадаад орчны шинжилгээ

	Боломж /Opportunities/	Саад тотрог /Threats/
1. Эдийн засгийн хүчин зүйлс	<ul style="list-style-type: none"> • Санхүүжилтийн эх үүсвэрүүд /хандив, төсөл, өөрийн үйл ажиллагааны орлого/ олон болж боловсролд оруулах гадаад, дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэж байна. Үүний дүнд боловсролын салбарт төрөл бүрийн хөтөлбөрүүд төсөл хэрэгжүүлэх боломж нээлттэй болсон. • Малчдын хүүхдийг сургуульд бүрэн 	<ul style="list-style-type: none"> • Хүүхдийн тоо цөөн байгаагаас төсөв бага. • Орон нутгийн захиргааны чадавх муу • Албан бус сургалт, зайны сургалт явуулах санхүүгийн эх үүсвэргүй. • Бүс нутгийн тэгш бус хөгжлөөс шалтгаалж боловсролын үйлчилгээ

хамруулж завсардалтыг багасгах зорилгоор төрөөс дотуур байрны зардлыг хариуцан санхүүжүүлэх болсон.

- Боловсролын салбарт хандивласан хөрөнгийг татвараас чөлөөлөх болсноор иргэд, аж ахуй нэгж сургуульд хандив өгөх боломжтой байгаа.
- Сургууль, багш нарын өрсөлдөөн бий болсноор сургалтын чанарт өөрчлөлт гарч суралцагчдын өрсөлдөөн бий боллоо.
- Боловсролыг хөгжүүлэхэд нийгмийн сонирхлын бүлгүүдийн оролцоо нэмэгдэж бүтээлч хамтын ажиллагаа бий болж байна.
- Сургууль, багш, суралцагчдын үйл ажиллагааг бодитойгоор үнэлж дүгнэх хөндлөнгийн хяналтын тогтолцоо бүрэлдэж эхэлж байна.
- Сургалтын технологийг бүхэлд нь шинэчлэх бодлого стратеги тодорхой болж байгаа
- Сургалтын тоног төхөөрөмж шинэчлэгдэж эхэлж байгаа.
- Сургалтын технологийг шинэчлэх тодорхой бодлого чиглэл бүхий нийтийг хамарсан сургалтууд эрчимжиж байна.
- Олон улсын төрөлжсөн байгууллагаас боловсролын хөгжилд оруулах хувь нэмэр дээшилж байна.
- Төрөлжсөн байгууллагын төсөл хэрэгжүүлэх боломжтой.

өндөр өртөгтэй байдаг.

- Газар нутгийн алслагдсан байдлаас багш нарын мэргэжил дээшлүүлэхэд зардал их шаардагддаг.
- Өрсөлдөөн хүчтэй болсноор өөрийн сургуулийн багш, суралцагч нараа алдах нөхцөл бий боллоо.
- Сэтгэлгээний болон арга барилын өөрчлөлт жигд бус
- Мэдээлэл хүлээж авах боломж сургуульд хангалтгүй
- Сургуулийн өмнөх насны хүүхдийн бэлтгэл жигд бус
- Тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээний хүртээмж чанар дорвитой дээшлээгүй.
- Чадварлаг, сэтгэлтэй ажиллах боловсон хүчин дутагдалтай

Эрүүл мэндийн үйлчилгээ

МУ-ын Хөдөлмөрийн баатар М.Минжигийн нэрэмжит

Эрүүл мэндийн төв

Говь-Алтай аймгийн Шарга сумын Хүн эмнэлэг нь анх 1932 онд Хасагтжаргалан сумд нэг ажилтан, нэг сувилагчтайгаар гэр эмнэлэг байгуулагдсан бөгөөд анхны сувилагчаар нь Орших ажиллаж байжээ. Аймгийн АДХГЗ-ны 1972 оны 09 сарын 10-ны өдрийн 01 тоот шийдвэрийн дагуу хүний их эмчийн салбар болон өргөжсөн.



Их эмч-2, НЭМ –ийн аргазүйч 1, дүн бүртгэгч бага эмч 1, эх баригч бага эмч 1, сувилагч 4, нягтлан бодогч 1, нярав 1, лаборант 1, багийн эмч 4, үйлчлэгч 3, тогооч 1, жолооч 1, эмийн санч 1, галч 4 гэсэн 26 орон тоотой ажиллаж байна.

Эрүүл мэндийн төвийн SWOT шинжилгээ

Давуу тал:	Сул тал:
<p>1.Сумын эмнэлгийн багаж , тоног төхөөрөмжийн хангалт шатлалын эмнэлгийн стандартад ойртсон.</p> <p>Эрүүл мэндийн санхүүжилт жилээс жилд нэмэгдэж байгаа</p> <p>Хууль, эрх зүйн таатай орчин бүрдэж , орон нутгийн бодлогын баримт бичгүүд боловсрогдсон</p> <p>Боловсон хүчний хангамж сайн</p> <p>Эмч мэргэжилтнүүд тогтвор суурьшилтай ажиллаж байгаа</p> <p>Физик эмчилгээний тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан</p> <p>Аймгийн төвд ойрхон</p>	<p>1.Лабораторийн тоног төхөөрөмж дутагдалтай.</p> <p>2. Цэвэр бохир усны системгүй</p> <p>3. Нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох үйлчилгээнд иргэдийн идэвх сул, Иргэдийн эрүүл мэндийн боловсрол, эрүүл зан үйл төлөвшөөгүй</p> <p>4. Мэдээллийн тогтолцоо, лавлагаа үйлчилгээ сул/интернетгүй, суурин утасгүй/,дотоод сүлжээгүй</p> <p>5. Багаар явах шаардлагатай боловч санхүүгийн боломж муу</p> <p>6. Эргэлтийн эмийн сангийн үйл ажиллагаа тогтвортой боловч үйл ажиллагаа явуулах статус байхгүй,</p>

4 баг эргэлт хийх мотоцикльтой	эмийн сангийн зориулалтын байргүй 7. Хүний нөөцийн бодлого сулаас нарийн мэргэжлийн эмч дутмаг, эмч нарыг мэргэшүүлэх асуудал дутмаг.
Боломж:	Саад бэрхшээлүүд:
<ol style="list-style-type: none"> 1. Европ болон уламжлалт анагаах ухааныг хослуулан хөгжүүлж уламжлалт болон нөхөн сэргээх эмчилгээ хийх /кабинет байгуулах 2. Багийн эмч нар багийнхаа иргэдийн дунд суурьшиж ажиллах 3. Интернет ашиглан тайлан, мэдээлэл солилцоо 4. Гэрэл цахилгааны эх үүсвэртэй төвлөрсөн эрчим хүчинд холбогдсон 5. Түргэн тусламжийн автомашинд парк шинэчлэлт хийгдсэн 6. Өвчлөлийн судалгаануудыг хийж нотолгоонд суурилсан ЭМАШТУ-г үзүүлэх 7. Төсөл, хөтөлбөр, зээл тусламжинд хамрагдах 8. Эмгүй эмчилгээний нэр төрлийг олшруулах 	<p>Эдийн засгийн хямрал үргэлжлэх</p> <p>Ажилгүйдэл, ядуурал нэмэгдэж нийгмийн үйлчилгээ хангалтгүй болох</p> <p>Шинэ ба сэргэж байгаа халдвар, цочмог халдвар тархах</p> <p>Орон нутагт байгалийн гамшиг тохиолдох</p> <p>Эмч, мэргэжилтнүүдийн тогтвор суурьшил муудах (хүүхэд, мэс гэх мэт)</p> <p>Багийн ард иргэд алслагдмал болохоор сургалт сурталчилгаанд хамрагдахад хэцүү</p>

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
<ol style="list-style-type: none"> 1. Эрүүл мэндийн тусламж нь эмнэлэгт шүтсэн /хэвтэн эмчлүүлэх / арга барилаар явагддаг 	<ol style="list-style-type: none"> 1. Үйлчлүүлэгч болон эмч, эмнэлгийн ажилтнуудын ажиллах, ая тухтай үйлчлүүлэх орчинг бий болгох зорилгоор стандарт шаардлага хангасан Эрүүл мэндийн төвийн
<ol style="list-style-type: none"> 2. Уламжлалт, нөхөн сэргээх, 	

хөнгөвчлөх эмчилгээ зэрэг үйлчилгээ өнөөгийн хэрэгцээ шаардлагын түвшинд хүрээгүй.

3. Эрүүл мэндийн боловсрол хангалтгүй, мэдээлэл, дэмжлэг дутмаг.

4. Эрүүл мэндийн төвийн одоогийн барилга нь үйл ажиллагаа явуулах эрүүл ахуйн стандарт шаардлагыг хангахгүй .

шинэ барилгатай болох

2.Эмч,эмнэлгийн ажилтнууд,сайн дурын идэвхтнийг нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр сургаж чадавхжуулан эмгүй эмчилгээний орчинг бий болгон үйл ажиллагааг тогтмолжуулах

3. Нарийн мэргэжлийн мэргэшсэн чадварлаг боловсон хүчнийг бэлтгэх

4. Зорилтот бүлэгт чиглэгдсэн НЭМТҮ –г үр дүнтэй хүртээмжтэй болгож иргэдийг эрүүл аж төрөх зөв дадал хандлагатай болгох, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг эрүүлжүүлэх хөтөлбөр боловсруулах

5. Хүүхдийн сувиллыг тогтмол ажиллуулж үр дүнг тооцох

6. Халдварт бус өвчний эрт илрүүлэлт,урьдчилан сэргийлэх үзлэгийн хамралтыг нэмэгдүүлж нүүдлийн амбулаторийг багт тогтмол ажиллуулах

Соёл, урлагийн үйлчилгээ:

1962 онд одоогийн соёлын төвийн барилга ашиглалтанд орж “Улаан булан нэртэйгээр нээгдэж сумын клубын анхны эрхлэгчээр Г.Мижиддорж, кино механикчаар н.Бүдрагчаа, үйлчлэгчээр н.Цэнджав гэсэн 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байсан байна.



Өнөөдөр манай соёлын төв нь эрхлэгч 1, хөгжмийн багш 1, номын санч 1, Орон нутаг сурталчлах танхимын ажилтан 1, үйлчлэгч, нярав 1, галч 3 гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж Шарга нутгийн бүтээлч, хөдөлмөрч ард түмэндээ урлаг соёлын үйлчилгээг хүргэхийн төлөө чармайн ажиллаж байна

Соёлын үйлчилгээний SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
Сумын өндөр настан, дунд үе, залуучууд спортын чиглэлээр хичээллэх, чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх, эрүүл мэнддээ их анхаарах болсон нь давуу талтай.	Сумд байгаа биеийн тамирын хоёр заалны талбай стандартад хэмжээндээ хүрэхгүй шахуу байдаг нь спорт сонирхогч, үзэгчид суух талбай багатай, орчин үеийн шаардлага нийцэхгүй, тав тухтай орчин хувцас солих өрөө болон бие засах газар бусад шаардлагатай нөхцөлүүд хангагдаагүй болно.
Боломж	Саад бэрхшээл
Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр жил бүр тодорхой хэмжээний төсөв хувиарлагдаж байгаа эхний жилд зураг төслийн зардлыг гаргаж дараагийн жилээс барилгыг барих боломжтой.	Одоо байгаа заалыг болж байна гэсэн дутмаг сэтгэлгээ байгаа. Иргэдэд зөв ойлгуулж чадвал дэмжигдэх боломжтой.

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудал

- Нэн тэргүүнд иргэдэд зөв ойлгуулж тав тухтай цэвэрхэн спортын төвтэй болох нь зүйтэй гэдэг чиглэл өгөх
- Төсөв хэтэрхий ойр зуурын зүйлд зарцуулагдаж байгааг болих

Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээ

ОНХС-ийн хөрөнгийг онцын шаардлагагүй олон жижиг зүйлд хөрөнгө зарлагадалгүй нүдэнд харагдахуйц ирээдүйгээ харсан том бүтээн байгуулалтад зоригтой орох хэрэгтэй байна.

Төрийн үйлчилгээ

Төрийн үйлчилгээний свот шинжилгээ

Давуу тал:

- Мэргэжилтэй боловсон хүчнээр хангагдсан.
- Төрийн үйлчилгээ ил тод болсон
Мэдээлэл холбоо хөгжсөн

Сул тал:

- Хэрэгжилтийг хангаж байгаа хууль тогтоомжууд зөрүүтэй байдаг нь иргэдийн итгэл үнэмшилд нөлөөлж байна
- иргэдийн санал санаачлага, оролцоо бага
- Ажлын ачаалал харилцан адилгүй Ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолт оновчгүй
- Интернетийн орчин хангалтгүй учир мэдээлэл авахад хугацаа алддаг.
- Албан конторын байр зориулалтын бус, хуучирч муудсан
- Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх байргүй

Боломж:

- Интернетийн орчин бий болгох
- Цаасгүй технологийг нэвтрүүлэх
- Төрийн үйлчилгээний шат дамжлагыг цөөрүүлэх
- Эрх зүйн орчинг боловсронгуй болгох

Саад, бэрхшээл:

- Төрийн үйлчилгээний шат дамжлага олон
- Төрийн албан хаагчдын цалин бага, нийгмийн баталгаа сул

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд

ЗДТГ, нэг цэгийн үйлчилгээний зориулалтын шинэ байртай болох

Хууль тогтоомжийн заалтуудын зөрүүтэй байдал

Төрийн албан хаагчийн нийгмийн асуудал

Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх арга хэмжээ

Ойрын жилд улсын төсвөөс шинэ байр бариулах асуудлыг шийдвэрлэх

Харилцан холбоотой хуулиудыг шинжилж, зөрчилтэй заалтыг нэг мөр болгох

Орон сууцтай болоход хөнгөлттэй зээл хөтөлбөрт албан хаагчдыг хамруулах

Нийгмийн халамж, даатгал, хөдөлмөрийн үйлчилгээ

Нийгмийн даатгал, халамжийн шинжилгээ

Давуу тал

- Иргэдийн хандлага өөрчлөгдөж нийгмийн даатгалд хамрагдах хүрээ нэмэгдэж байгаа
- Ажиллах орчин нөхцөл техник хэрэгслээр бүрэн хангагдсан.

Боломж

- Нийгмийн халамжид хамрагдах эрх үүссэн хүн бүрийг хамруулах боломжтой.
- Иргэн бүр нийгмийн даатгал, нийгмийн халамжийн хууль тогтоомжийг мэдээллийн бүх сувгаар авах боломжтой.
- Багийн засаг дарга нар болон бусад ажил мэргэжлийн хувьд холбогдох албан тушаалтнуудтай хамтарч баг болон ажиллах сургалт сурталчилгаа явуулах боломжтой

Тулгамдаж буй асуудал

- Нийгмийн даатгалд хамрагдах хүрээг нэмэгдүүлэх

Сул тал

- Иргэдийн хуулийн мэдлэг мэдээлэл дутмагаас гадна хувь хүний хайхрамжгүйгээс даатгалд хамрагддаггүй хугацаа алддаг
- Малчдын нийгмийн даатгалд хамрагдах эрх зүйн орчин сайн дурын үндсэн дээр зохицуулагддаг тул хамрагдалт бага

Саад бэрхшээл

- Иргэд хэвлэл мэдээллийн хэрэгслээс буруу ташаа мэдээлэл авснаас шалтгаалан тухайн байгууллагад болон даатгуулсныхаа ашиг тусыг хүртэх эсэхэд итгэх итгэл суларсан
- Нийгмийн даатгалын байцаагч болон халамжийн мэргэжилтэн ганцаараа сургалт сурталчилгаа хийхэд хүн бүрт хүрэх боломжгүй
- Ажлын ачаалал их

Шийдвэрлэх арга хэмжээ

- Сургалт сурталчилгааг сайжруулах

**Байгаль
орчны
салбарын
хөгжил**

Байгаль орчин СВОТ шинжилгээ

Давуу тал:

- Эмчилгээний чанар бүхий рашаантай
- Байгалийн нөөц, ашигт малтмал судлагдаж байгаа \хөнгөн цагаан, алт, зэс, нүүрс гэх мэт\
- Байгалийн нөөц баялаг ашигласны төлбөр хураамж нэмэгдэж байгаа

Сул тал:

- Ундны ус хатуулаг ихтэй
- Байгаль хамгаалах талаар иргэдийн санал санаачлага, оролцоо бага
- Ногоон байгууламж бага
- Байгалийн нөхөн сэргээлт хийгдэхгүй байгаа
- Хөрсний сулрал, элсний нүүдэл их
- Цөлжилт явагдаж эрчимтэй явагдаж

- Байгалийн үзэсгэлэнт газруудтай

байгаа

- Бэлчээрийн даац хэтэрсэн

Боломж:

- Рашаан сувилал хөгжүүлэх
- Ашигт малтмалын орд нээх
- Мод тарьж, элсний нүүдэл зогсоох
- Малын бэлчээрт худаг гаргах

- Байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөл байгуулах
- Шахмал түлшний цех байгуулах

Саад, бэрхшээл:

- Усны нөөц хомсдох
- Байгаль цаг уурын эрс тэс өөрчлөлт гарч, давтамж ойртсон
- Цөлжилт үүсч бэлчээрийн хомсдол бий болох
- Бэлчээрийн хортон мэрэгч ихсэж байгаа
- Булаг шанд ширгэж байгаа

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд

Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх арга хэмжээ

Бэлчээрийн хортон мэрэгчийг устгах

Төсөл хөтөлбөрөөр болон малчдын санаачилгаар үлийн цагаан оготныг устгах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх

Бэлчээрийн доройтлыг багасгах

Сүргийн зохистой харьцааг бий болгох санал санаачилгыг малчдад ойлгуулах

Элсний нүүдэл

Заган ойг өтгөрүүлэх

Шарга сумын эдийн засгийн чадавхийн үнэлгээ

Үнэлгээ хийсэн арга зүй, зохион байгуулалт Сумын эдийн засгийн хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулж хэрэгжүүлж байгаагаас орон нутгийн эдийн засгийн хөгжлийн чадавхи хамаардаг. Энэ удаад сумын эдийн засгийн хөгжлийн үнэлгээг хийхдээ маркетинг сурталчилгаа, хөрөнгө оруулагч нартай холбоо тогтоох байдал, бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх улмаар стратеги төлөвлөлтийн үйл явцыг дэмжих, урамшуулал бий болгох санхүүжилт олгох, ажиллах хүчний хөгжил, эдийн засгийн хөгжлийн төслүүдийг бэлтгэх, хянах, Орон нутгийн эдийн засгийн хөгжлийн төслүүдийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, мэдээллийн сантай болох, үйл ажиллагаагаа тайлагнах, олон нийтийн харилцаа зэрэг олон чухал үзүүлэлтүүдийг хамарсан асуулга бүхий хүснэгтийг ашигласан юм.

Манай сумын эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмэр, үүргийн чадавхийн үнэлгээг сумын Төлөвлөлт хяналтын хорооны гишүүд, албан байгууллагын удирдлагууд, бизнес эрхлэгчид, иргэд, малчдын төлөөлөл болсон 108 хүнээс санал авч тодорхойлуулж дүгнэлээ.

ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

д/д	Үүргүүд	Үнэлгээ					Сумын дундаж
		1	2	3	4	5	
1	Маркетинг	42	47	12	3	4	1.81
2	Хөрөнгө, оруулагчтай холбоо тогтоох	17	34	44	12	1	2.46
3	Орон нутгийн бизнес эрхлэгч нартай холбоотой байх	13	26	44	23	2	2.85
4	Стратеги төлөвлөлтийн үйл явцыг дэмжих	17	27	42	15	7	2.65
5	Урамшуулал бий болгох санхүүжилт олгох	24	30	41	6	7	2.46
6	Ажиллах хүчний хөгжил	9	40	31	22	6	2.70
7	Эдийн засгийн хөгжлийн төслүүдийг бэлтгэх хянах	16	38	36	10	8	2.60
8	ОНЭЗХ-н төслүүдийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх	9	30	47	13	9	2.80
9	Засаг дарга болон Иргэдийн хурлын зөвлөгөө мэдээллээр хангагдах түвшин	7	14	41	31	15	3.30
10	Эдийн засаг хөгжлийн асуудал хариуцсан төв байгууллагатай харилцаа тогтоон ажиллах	15	37	36	12	8	2.63
11	Мэдээллийн сан байгуулах	7	26	46	23	6	2.95
12	Үйл ажиллагаагаа тайлагнах	4	10	49	32	13	3.37
13	Олон нийтийн харилцаа	8	23	45	20	12	3.05
Д Ү Н							

Тайлбар;

- 1- Маш бага чадавхтай, эсвэл тухайн үүрэг огт биелэгддэггүй
- 2- Тухайн үүрэг маш бага түвшинд биелэгддэг
- 3- Энэ чиглэлд хүчин чармайлт гаргаж байгаа, гэхдээ цаашид улам сайжруулах шаардлагатай
- 4- Энэхүү үүрэгт хамаарах сумын чадавхи нь сайн
- 5- Сум нь энэхүү үүргийг маш сайн биелүүлдэг, өндөр хөгжсөн чадавхтай

Сумын чадавхийн үнэлгээний голлох дүгнэлтүүд:

1. Маркетинг, Зах зээлийн хөгжил 1.81 байгаа нь тухайн үүрэг маш бага түвшинд биелэгддэг.

2. Мэдээллийн сан байгуулахаас бусад чиглэлийн үүргийг 2.45-2.85 баллын хооронд буюу энэ чиглэлд хүчин чармайлт гаргаж байгаа гэхдээ цаашид улам сайжруулах шаардлагатай гэсэн үнэлгээтэй байна.

3. Сумын чадавх хамгийн ихдээ 3,37 буюу тухайн үүрэгт хүчин чармайлт гаргаж байгаа, гэхдээ цаашид улам сайжруулах шаардлагатай гэж үнэлсэн байна.

4. Маш сайн биелүүлдэг, өндөр чадавхтай гэсэн дүгнэлт огт гараагүй нь сумын хөгжлийн чадавх тийм ч сайн биш гэдгийг харуулж байна.

Шарга сумын бизнесийн орчны судалгааны үр дүн ба дүгнэлтүүдийн тойм

Гурав. СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ШАРГА сумын хөгжлийн “Алсын хараа”

ХҮНЭЭ ХӨГЖҮҮЛЖ, БАЙГАЛИА ДЭЭДЭЛСЭН, ЭДИЙН ЗАСАГ-ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛӨӨРӨӨ МАНЛАЙЛАГЧ СУМ БОЛНО.



ШАРГА сумын хөгжлийн тэргүүлэх чиглэл

- Эрчимжсэн Мал аж ахуй, газар тариаланд түшиглэн хоршоо, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх.
- Цахилгааны найдвартай эх үүсвэр уул уурхайг түшиглэн дэд бүтцийг цогцоор нь хөгжүүлэх.
- Байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалан эдийн засгийн үр өгөөж бүхий аялал жуулчлал хөгжүүлэх

ШАРГА сумын хөгжлийн үндсэн “Зорилгууд”

ЗОРИЛГО-1. ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЖ, АРД ИРГЭДИЙН АЯ ТУХТАЙ АМЬДРАХ, АЖИЛЛАХ ОРЧНЫГ БҮРДҮҮЛНЭ

ЗОРИЛГО-2. ИРГЭДЭД ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЧАНАР ХҮРТЭЭМЖТЭЙ ХҮРГЭЖ ХҮН АМЫН ӨСӨЛТИЙГ БОДЛОГООР ДЭМЖИН АЖИЛЛАЖ АМЬДРАХ ТААТАЙ ОРЧИНГ БҮРДҮҮЛНЭ.

ЗОРИЛГО-3. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ УУЛ УУРХАЙГ ТҮШИГЛЭСЭН БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСГИЙГ ЦОГЦООР НЬ ХӨГЖҮҮЛЭХЭД ОРШИНО.

ЗОРИЛГО-4 УЛАМЖЛАЛТ МАЛ АЖ АХУЙГАА ЭРХЛЭН УЛМААР ХАА-Н САЛБАРЫГ ЭРЧИМЖҮҮЛЖ, ЖДҮ-ИЙГ ХӨГЖҮҮЛНЭ.

Төлөвлөгөөний хамрах үе шат

СУМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ 2013-2023 ОНЫ ХУГАЦААНД ХАМРАН ХЭРЭГЖИХ БӨГӨӨД ХУГАЦААНЫ ХУВЬД ГУРВАН ҮЕ ШАТТАЙ БАЙНА.

Үүнд: 1-р үе шат 2014-2016 он
 2-р үе шат 2017-2020 он
 3-р үе шат 2021-2024 он

- Хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх үе шат
- 1-р үе шат (2014-2016)
- Хөгжилд шаардлагатай нөөцүүдийг бүрдүүлэх, хөгжлийн суурь нөхцөлийг хангах үе шат
- 2-р үе шат (2017-2020 он)
- Бүтээн байгуулалт, эрчимтэй хөгжлийн үе шат
- 3-р үе шат (2021-2023 он)

Төлөвлөгөө боловсруулсан үйл явц, зохион байгуулалт:

Сумын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүйн сургалт, зөвлөгөө



ШАРГА СУМЫН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

ЗОРИЛГО		ЗОРИЛТ	
1.	ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЖ, АРД ИРГЭДИЙН АЯ ТУХТАЙ АМЬДРАХ, АЖИЛЛАХ ОРЧНЫГ БҮРДҮҮЛНЭ	1.1	Зам тээврийн хөгжлийг түргэтгэж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.
		1.2	Орчин үеийн хот байгуулалтыг бий болгож, тохилог тав тухтай ажлын байр, амьдрах орчныг бүрдүүлнэ.
		1.3	Сумын төвийн өнгө үзэмж, орчны тохижилтыг сайжруулна.
		1.4	Мэдээлэл харилцаа холбоо, шугам сүлжээг өргөтгөн шинэчилнэ.
2.	ИРГЭДЭД ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЧАНАР ХҮРТЭЭМЖТЭЙ ХҮРГЭЖ, ХҮН АМЫН ӨСӨЛТИЙГ БОДЛОГООР ДЭМЖИЖ, СУРЧ АМЬДРАХ ТААТАЙ ОРЧИНГ БҮРДҮҮЛНЭ	2.1	Төрийн үйлчилгээг иргэдэд ил тод шуурхай хүргэж, мэргэшсэн боловсон хүчнээр хангана.
		2.2	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний орчин нөхцөл, чанар хүртээмжийг сайжруулж хүн амын өвчлөлийг бууруулна.
		2.3	Боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, сургалтын орчинг сайжруулна.
		2.4	Соёлын үйлчилгээний цар хүрээг өргөжүүлж, иргэдийн гоо зүйн боловсролыг дээшлүүлнэ.
3.	НОГООН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЖ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙГЭЭР ХӨГЖҮҮЛНЭ	3.1	Байгалийн өвөрмөц тогтоц бүхий газруудыг түшиглэн аялал жуулчлалын бааз байгуулна.
		3.2	Байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөл, бүлгийг дэмжиж байгалийг унаган төрхөөр нь байлган, ард иргэдийг ногоон орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.
		3.3	Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалж, хүүхэд залуучуудад сурталчлан таниулна.
4.	УЛАМЖЛАЛТ МАЛ АЖ АХУЙГАА ЭРХЛЭН УЛМААР ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫГ ЭРЧИМЖҮҮЛЭН ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛНЭ.	4.1	Уламжлалт мал аж ахуйг эрчимжүүлж, малын үүлдэр угсааг сайжруулан сүргийн зохистой харьцааг бүрдүүлнэ
		4.2	Газар тариалан эрхлэлтийг нэмэгдүүлж, хадлангийн талбайн ашиглалтыг сайжруулан, дэвшилтэт техник, тоног төхөөрөмжийг нэвтрүүлж, 1 га-гаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлнэ
		4.3	Өрхийн үйлдвэрлэл болон жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэн ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулж туслах аж ахуйг эрхлэн хөгжүүлж эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангана

Шарга сумын бизнесийн орчны судалгааны үр дүн ба дүгнэлтүүдийн тойм

БИЗНЕСИЙН ОРЧНЫ СУДАЛГААНЫ ДҮН

Суманд үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэгчдийн одоогийн байдал, чадавхийг үнэлэх, бизнес эрхлэх таатай ба тааламжгүй нөхцлийг бизнес эрхлэгчдийн өөрсдийнх нь үнэлэмжид тулгуурлан тодорхойлох, сумынхаа эдийн засгийг хөгжүүлэх, бизнесийн орчныг сайжруулах төлөвлөгөөнд ямар асуудал тусгах, ямар арга хэмжээ авч явуулах нэн чухал шаардлагатай байгааг тодруулах зорилгоор төрөл бүрийн бизнес эрхэлдэг 80 хүнээс тусгай боловсруулсан асуулгын дагуу судалгаа авч, нэгтгэн боловсруулж, тодорхой дүгнэлтүүд гаргав.

Судалгаанд хамрагдагсад

- Судалгаанд оролцогчид нь мал аж ахуйн 40, газар тариалангийн 20, худалдаа үйлчилгээний 10, бусад 10 хүн байв.
- Судалгаанд хамрагдагсдын бизнес эрхэлсэн хугацааг нь авч үзвэл 25% нь 5 хүртэл жил ажилласан, 37.5% нь 5-10 жил ажилласан, 37.5 % нь 11-ээс дээш жил ажилласан байлаа.
- Дээрхи нэгжүүдийн 93,7% нь 5 хүртэл, 6,3% нь 6-аас дээш ажиллагсадтай байсан.

Бизнесийн орчин нөхцлийн ирээдүйн байдал

Судалгаанд оролцогчдын 88,75 хувь нь өөрсдийн бизнесийн ирээдүйг өөдрөг гэж үнэлсэн байхад, 11,25 хувь нь явцгүй гэж үзсэн байна.

Бизнесээ яаж өргөтгөх вэ? гэсэн асуултанд 65 % нь хэмжээг нэмэгдүүлэх, 13,75 % нь эрчимжүүлэх, 5 % нь бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, 16,25 % нь зах зээлээ өргөтгөх гэж хариулсан байна.

Бизнесээ өргөтгөн хөгжүүлэх бололцоо танай суманд бий юу? гэсэн асуултыг үйлдвэрлэлийн нөөцүүд болон дэд бүтцийн салбарууд тус бүрээр тавьсан бөгөөд үүнд хэрхэн хариулсныг дараах дүнгүүдээс харж болно. /хариулт, хувиар/

Үйлдвэрлэлийн нөөцүүд	Хүрэлцээтэй	Дунд зэрэг	Байхгүй
Газар	46,25	23,75	30
Эрчим хүч	90	10	-
Зам	13,75	40	46,25
Холбоо	93,75	6,25	-
Инженерийн байгууламж	-	8,75	91,25
Түүхий эд материал	47,5	45	7,5
Санхүүгийн эх үүсвэр	6,25	16,25	77,5
Мэргэжилтэй ажиллах хүчин	42,5	30	27,5

Бизнес эрхлэхэд ямар саад бэрхшээл байна вэ? гэсэн асуултад 80 хүнээс давхардсан тоогоор нийт оролцогсдын 16,3 % нь байр, санхүүгийн боломж муу, 20,3 % нь зах зээл багатай, 4,7 % нь бэлчээрийн усан хангамж муу, 6,1 % нь татварын дарамт их, 19,5 % нь банкны зээлийн хүү өндөр, 8.2 % нь шатахууны үнийн өсөлт, 7,4 % нь худалдан авах чадвар муу, 4,2 хувь нь мэргэжилгүй, мэргэжилтэй боловсон хүчин дутмаг, 2,4 % нь цахилгаан эрчим хүч дутмаг, 10,3 % нь тоног төхөөрөмж дутагдалтай гэж үзсэн байна.

Бүтээгдэхүүнээ хаана борлуулдаг вэ? гэсэн асуултад 77,5 % хувь нь сумандаа, 22,5 хувь нь аймагтаа болон бүс нутагтаа борлуулдаг гэжээ.

Борлуулалтаа нэмэгдүүлэх үү? гэсэн асуултад 93,75 % нь нэмэгдүүлнэ гэсэн байхад 6,25 % нь үгүй гэж хариулснаас үзэхэд хүн бүр бизнесээ өргөжүүлж, орлогоо нэмэгдүүлэх зорилготой нь ажиглагдаж байна.

Бизнес эрхлэгчдийн дийлэнх нь бүтээгдэхүүнийхээ чанарыг сайжруулах, захиалагчаа зөв сонгох, нэр төрлийг олшруулах, борлуулах цэгээ нэмэгдүүлэх, шинэ зах зээл эзэмших замаар борлуулалтаа нэмэгдүүлнэ гэжээ.

Мэргэжилтэй ажилчид хүрэлцээтэй юу? гэсэн асуултад 51,25 % нь тийм, 48,75% нь үгүй гэж хариулснаас үзвэл мэргэжилтэй ажилчид дутагдаж байгаа нь харагдаж байна.

Ажилчдын ур чадварыг дээшлүүлэхэд хамгийн гол гэж үзэж байгаа сургалт аль нь вэ? гэсэн асуултанд хамгийн түрүүнд өөрсдийн чадавхаа бэхжүүлэх, санхүү ня-бо бүртгэл, компьютер, менежмент, технологийн чанарын сургалтууд байна.

Сумын эдийн засгийн хөгжлийн үнэлгээ

Бизнесийн орчны өөрчлөлт хандлагыг 86,25 % нь сайжирсан, 13,75 % нь өөрчлөгдөөгүй гэж үзсэн байна. Энэ нь бизнесийн орчин сайжирсан болохыг илэрхийлж байна. Харин сумын эдийн засгийн хөгжлийг нийт оролцогчдын 51 % нь зогсонги, 49% нь буурч байгаа гэж үнэлжээ.

Сумын эдийн засгийн хөгжилд үзүүлэх таны хувь нэмэр юу вэ? гэсэн асуултанд 25 хувь нь бизнесээ өргөжүүлж ажлын байр нэмэгдүүлнэ, 15 хувь нь цэвэр орчинг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулна, 17,5 хувь нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээ нэмэгдүүлнэ 42,5 нь малаа өсгөнө, худалдаа, үйлчилгээний чанарыг сайжруулна гэсэн хариултыг өгсөн байна.

Ажилгүйдэл, ядуурлыг бууруулахын тулд, 27,5 хувь нь ажлын байраар хангах, 35 хувь нь жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, 11,25 хувь нь төрөл бүрийн сургалтанд хамруулах, 26,25 хувь нь төрөл бүрийн төсөл хөтөлбөрт хамруулах шаардлагатай гэж хариулсан байна.

Сумын хөгжлийн үзэгдэл

Манай сум нь Төв-Атай аймгийн хойд хэсэгт оршдог бөгөөд ан амьтан, урлаг, ус зэвсгийн үзэмжтэй нутаг билээ. Энэ сайхан нутгаа цэвэр ариунаар нь байлгас үзэгдэл сайхнаар төлөөлж байна.

Хүүхэд багачууд бид одоогоос эхлэн хамт нэгдэн суурь хөгжлийн үзэгдэлд их хувь нэмэр оруулахаар хичээж байна. Оршин суугчид нутгаа хөгжүүлэхийн тулд хөгжлийн хөгжлийн үйл ажиллагаа бусад зүйлсэд идэвхтэй байж чадна гэдэг хэрэгтэй. Сумын дэд бүтэц сайн хөгжснээр өндөр өндөр баримтаар гүйцэтгэж, үйлдвэр хөдөө аж ахуй, газар тариалан, төлөм зүйл зурхай, интернет гээд бүх зүйлд арга түмэн хөлс хүчээ зарцуулж ажилласнаар Улаанбаатар болон төв суурин газар руу шилжих хөдөлгөөн зүйл болох юм. Ийнхээр амьдрал дээшлэх хүн арг маань эртэй хөгжлийн амьдрал зам нээгдэнэ.

Аливаа байгууллагууд нь төрийн их хан хуурыг хоймортоо дагаж, айм төрийн эзэнтэй нартай сүүнийгээ дээшлэх хангай дүхнийгээ оршдог нь үзэгдэлд сайн явахад үүд юм. Үндэрийн далай гэгдэхийнхэн хамттай болж байгаа нь маш том амжилт, амжилт билээ. Зөвхөн сумынхаа төвийн и хөгжүүлж гэг сайхан болгохыг хөгжилт байна гэж болохгүй түүнийгээ далаад хүн арг, малчин түмэн нь дүхийн сөйтэй хөгжилт амжилт хөдөө малчлох хөгжилт интернет, харилцаа холбоо, гэр утас гээд идэвхтэй авч болохуйц бүх зүйл тэдэнд хүрч гэдвэл өөрсө улаан нь дээшлэхээр сум орон нутаг маань хөгжих маш том түмэн болно.

Монголын алдарт гучин гурван төвийн нэг Шаргон төвд дүхийн өмнө мөнхлэн түүнийг ирж илгэний ундаанг рашаан сувиллаар сувилуулж байна. Таван хөшүү мал, ан амьтан, урлагтаар зөв дэгл нутагт бид амьдарч байгаагаа баярладаг.

Манай сум нь хөгжсөөр и хөгжсөөр и байгаа билээ. Үн 226

10-д аймгийн урлаг Ф. Гэрэнгашев -

Энэ ашигт ураны Л. Энхтүвшин. 197-үй.

Уриан хөгжлийн үрэгдүй.

Монгол бөхөн хатурсан, мал үрэг нь таваараа
идэшилсэн, алтан шаргал энэ хамураа
хуулирсан, ага шийт энэ орно гуниг үрван
ловийн энэ Шаргал говь билээ. "Хөгжлийн үрэгдүй"
-ийн би угаан урандүүлэн толгойлоо
